

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ



Мандах Их Сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2023оны
10 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэн сайшаав

МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН ХӨТӨЧ

(Доктор, магистрын хөтөлбөрөөр суралцагчдад зориулсан лавлах)



Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, УРИА, ҮНЭТ ЗҮЙЛС	6
МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТҮҮХЭН ТОВЧОО.....	7
МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	8
МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУД.....	9
МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН УДИРДЛАГА	10
МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ЧАНАР МЕНЕЖМЕНТИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО.....	11
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ	15
1.1 АТС-ИЙН ЭРДЭМТЭН, БАГШ НАР	16
1.2 МАНДАХ ЭРДЭМ СЭТГҮҮЛ.....	23
1.3 НОМЫН САН.....	23
1.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЛАБОРАТОРИ СУРГАЛТЫН ОРЧИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ.....	33
1.5 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	34
1.6 АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛИАС ЗОХИОН БАЙГУУЛДАГ СУРГАЛТУУД	38
1.7 ЦАХИМ СУРГАЛТЫГ АШИГЛАХ ЗААВАР.....	40
1.8 Е-МАНДАХ УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ	51
ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ.....	62
2.1 СУРГАЛТ ЯВУУЛЖ БУЙ МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРҮҮД.....	62
2.1.1 САНХҮҮГИЙН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР.....	62
2.1.2 БИЗНЕСИЙН УДИРДЛАГА МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР	65
2.1.3 ДААТГАЛ МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР	68
2.1.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР.....	71
2.1.5 БАНК МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР	74
2.2 СУРГАЛТ ЯВУУЛЖ БУЙ ДОКТОРЫН ХӨТӨЛБӨР	77
ГУРАВДУГААР БҮЛЭГ: МАНДАХ ИХ СУРГУУЛЬД МӨРДӨХ ДҮРЭМ ЖУРАМУУД	81
3.1 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ.....	81
Нэг. Ерөнхий зүйл.....	81
Хоёр. Бүртгэл, тавигдах шаардлага.....	81
Гурав. Элсэгчдийн шалгаруулалт.....	81
Дөрөв. Суралцах эрхийн баталгаажуулалт.....	82
Тав. Элсэгчдэд үзүүлэх хөнгөлөлт	82

Зургаа. Бусад	83
3.2 МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТ ЭРХЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ.....	83
Нэг. Нийтлэг үндэслэл.....	83
Хоёр. Элсэлтийн үйл ажиллагаа.....	83
Гурав. Магистр, докторын сургалтад тавих үндсэн шаардлага	84
Дөрөв. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багц цаг, хичээлийн агуулга	85
Тав. Суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх	89
Зургаа. Суралцагчийн дүнгийн стандарт үнэлгээ.....	90
Долоо. Магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын багц цаг тооцоход.....	92
Найм. Магистр, докторын зэрэг хамгаалуулах	93
Ес. Суралцагчийн шилжилт хөдөлгөөн	96
Арав. Сургуулиас хасагдах	97
Арван нэг. Төгсөлт.....	97
хавсралт №1. Дипломын ажил бичих, хамгаалах үйл явцын зураглал.....	99
хавсралт №2. Докторын сургалтын үйл явцын зураглал	100
хавсралт №3. Диплом бичих суралцагчийн хүсэлт	101
хавсралт №5. Дипломын ажил бичих үйл явцад өгсөн удирдагчийн үнэлгээ	103
хавсралт №6. Дипломын ажлын шүүмжлэгчийн тодорхойлолт	104
хавсралт №7. Санал авах хуудас	105
хавсралт №8. Дипломын ажлын хамгаалалтын үнэлгээ	106
3.3 МАНДАХ ИХ СУРГУУЛЬД ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭХ ЖУРАМ	107
Нэг. Нийтлэг үндэслэл.....	107
Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт	107
Гурав. Хичээл дүйцүүлэхэд баримтлах ерөнхий шаардлага	107
Дөрөв. Багц цаг шилжүүлэн тооцох аргачлал.....	109
Тав. Суралцагчийн үнэлгээ (дүн)-г дүйцүүлэх аргачлал	109
Зургаа. Хэлний шалгалтын оноог дүйцүүлэх.....	110
Долоо. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа.....	110
Найм. Бусад	110
3.4 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛЫН БАГЦ ЦАГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ	116
Нэг. Нийтлэг үндэслэл.....	116
Хоёр. Эрдэм шинжилгээний багц цаг тооцох	116

Гурав. Магистрын мэргэжлийн дадлага хийх, хамгаалах.....	117
3.5 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ.....	118
Нэг. Нийтлэг үндэслэл.....	118
Хоёр. Оюутны ёс зүйн зарчим.....	118
Гурав. Ёс зүйн зөрчилд хамрагдах үйлдлүүд.....	118
Дөрөв. Бусад.....	119
3.6 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ.....	120
Нэг. Нийтлэг үндэслэл.....	120
Гурав. Холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурал.....	120
Дөрөв. Холбооны тэргүүлэгчдийн хурал.....	121
Тав. Холбооны гишүүдийн эрх, үүрэг.....	122
Зургаа. Холбооны санхүүжилт.....	122
3.7 МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭЛД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ.....	123
Нэг. Нийтлэг үндэслэл.....	123
Хоёр. Ажлын зохион байгуулалт.....	123
Гурав. Шилдэг бүтээлийн шалгаруулалт.....	124
Дөрөв. Санхүүжилт.....	124
3.8 ДОКТОРЫН ДАРААХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТЭТГЭЛЭГ.....	126
Нэг. Нийтлэг үндэслэл.....	126
Хоёр. Судалгааны ажлын тэтгэлэгт нэр дэвшүүлэх.....	126
Гурав. Тэтгэлэг олгох шалгаруулалт.....	126
Дөрөв. Судалгааны ажлыг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах.....	127
3.9 МАНДАХ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГСДЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ.....	130
Нэг. Ерөнхий зүйл.....	130
Хоёр. Сургалтын төлбөрийг тогтоох.....	130
Гурав. Сургалтын төлбөрийг төлөх хугацаа.....	130
Дөрөв. Суралцагчийн шилжилт хөдөлгөөн, сургалтын гэрээ дуусгавар болгох болон цуцлах үед хийгдэх тооцоо.....	130
Тав. Бусад.....	131
3.10 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ДЭГ.....	133

МЭНДЧИЛГЭЭ

Сурахын хүслээр жигүүрлэн илүү гэрэлт ирээдүйг цогцлоох зорилго тээн Мандах их сургуулийн эрдмийн босгоор алхаж буй эрхэм магистрант, докторант залуус та бүхэндээ нэн түрүүнд баяр хүргэж мэндчилье.

Мандах Их сургууль 2015 оноос цахим сургалтын системээ ашиглан магистрын хөтөлбөрийн сургалтаа цахим болон танхим хосолсон хэлбэрээр явуулж байгаа бөгөөд Магистр докторын сургалт судалгааны ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс сургуулийн удирдах зөвлөлийн шийдвэрээр 2021 онд ахисан түвшний сургуулийг нээсэн билээ.

Ахисан түвшний сургуулийн хамт олон магистр, докторын сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг явуулж, шинжлэх ухаан, технологийн шинэ ололт амжилт, инновацыг практикт нэвтрүүлэх арга замыг тодорхойлох мэдлэг, чадвартай үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх судлаачдыг бэлтгэх зорилго тавин ажиллаж байна.

Анх 2001 оноос магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж магистрын сургалт, судалгааны ажлыг эхлүүлсэн ба 2003 онд анхны төгсөлтөө хийснээс хойш 25 удаа төгсөлт хийгээд байна. Энэ хугацаанд магистрын хөтөлбөрийн дэд хороог байгуулан, магистрын хөтөлбөрийн шинэчлэл сайжруулалтыг тасралтгүй хийснээр 2018 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн. 2018 оноос бизнесийн удирдлагын докторын хөтөлбөрийг нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, эдийн засаг, менежментийн чиглэлээр өргөтгөн хэрэгжүүлж, олон шилдэг судлаачид болон багш нарыг өсөн дэвшихэд нь бодит хувь нэмэр үзүүлсээр байгаа билээ.

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн хамт олон бидний үндэсний хэмжээнд “Шилдэг багш нар”, “Шилдэг оюутан”, “Шилдэг хөтөлбөр”, “Шилдэг судалгаа эрдэм шинжилгээ”, “Шилдэг удирдлага менежмент”, “Шилдэг орчин нөхцөл”, “Шилдэг төгсөгчид” гэсэн алдрын оргил руу зорин тэмүүлэх үйлсэд нэгдэн энэхүү сургуулийн нэг гишүүн болж хамтдаа хөгжин дэвших хүсэл тэмүүлэлтэй та бүхэндээ дахин талархал илэрхийлж эрдмийн гэгээн үйлсэд тань амжилт хүсье.

**МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО,
УРИА, ҮНЭТ ЗҮЙЛС**



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТҮҮХЭН ТОВЧОО



1992 он
Бүдхүүгийн Сандгүсрэнгийн санаачилгаар МАНДАХ ИХ СУРГУУЛЬ үүсгэн байгуулагдв.



1996 он

- Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлээ.
- Анхны төгсөлтөө хийлээ.



1998 он

- Нягтлан Бодох Бүртгэлийн улсын Олимпиадыг санаачлан зохион байгуулав.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын анхдугаар олимпиадад ТЭРГҮҮН байр эзлэв.
- Сургууль өөрийн хичээлийн байртай болов.



2000 он

- Дундговь аймагт салбар сургуулиа нээв.
- Нийслэлийн Хэрэглэгчдийн найдвартай түнш байгууллага болов.

2001 он

- Нягтлан бодох бүртгэлийн улсын дөрөвдүгээр олимпиадад тэргүүн байр эзлэв.
- Магистрын хөтөлбөр нээв.



2002 он

- Нягтлан Бодох Бүртгэлийн улсын тавдугаар олимпиадад тэргүүн байр эзлэв.
- 10 жилийн ойгоо тэмдэглэв.



2010 он

- Монголын хувийн Их дээд сургуулиудын Холбооноос "Шилдэг их, дээд сургууль"- иэр шалгаруулж Хүндэт өргөмжлөл олгов.
- Дархан-Уул аймаг дахь салбар сургууль Дархан-Уул аймгийн "Шилдэг менежменттэй сургууль"-аар шалгарав.



2007 он

- Дархан - Уул аймагт салбар сургууль нээв.
- Бизнес хөгжлийн гарц холбооноос Оны шилдэг аж ахуйн нэгж цом өргөмжлөөр шагнав.



2006 он

- Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэгдэв.
- Нийгмийн даатгалын ерөнхий газраас "Улсын тэргүүний шимтгэл төлөгч" хүндэт өргөмжлөл хүртээв.



2005 он

- Хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдэв.
- Нягтлан бодох бүртгэлийн VII олимпиадад 2 байр эзлэв.



2003 он

- "Тэргүүний татвар төлөгч байгууллага" гэрчилгээ хүртэв.
- "Хэрэглэгчийг Хаанд өргөмжилсөн хамт олон" өргөмжлөл хүртэв.
- Магистрын анхны төгсөлт болов.



2012 он

- НББ-ийн 15-р олимпиадад тус сургуулийн оюутнууд амжилттай оролцсон ТОП-10-ын эхний 5 байрт шалгарч багийн дүнгээр Алтан медаль хүртэн үнэмлэхүй амжилтыг тогтоов
- 20 жилийн ой тэмдэглэв.



2014 он

- АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг ACBSP байгууллагаар сургууль болон сургалтын хөтөлбөрүүдээ магадлан итгэмжлүүлсэн Монголын анхны хувийн их сургууль боллоо.



2015 он

- Хувийн их дээд сургуулиудын холбооноос "Чанарын баталгаажуулалттай сургууль" өргөмжлөл олгов.



2016 он

- Менежментийн улсын олимпиадад Дархан салбар сургуулийн баг Тэргүүн байр эзлэв.
- "Татварын бүртгэл-2016" он-лайн олимпиадад Тэргүүн байр эзлэв.
- Хаан банкны нэрэмжит олимпиадад багийн дүнгээр 2-р байрт шалгарав.
- Нягтлан бодох бүртгэлийн улсын XVIII олимпиадад Дархан салбар сургууль хоёрдугаар байр, төв сургууль гуравдугаар байрт шалгарав.



2020 он

- ISO21001:2018 Боловсролын менежментийн тогтолцоог Монголын боловсролын байгууллагаас анх түрүүн хэрэгжүүлж, гэрчилгээ гардан авлаа.
- Хичээлийн С байрыг ашиглалтад оруулав.
- Оюутны байрыг ашиглалтад оруулав.
- Мандах лицей ахлах сургууль байгуулав.



2019 он

- НББ-ийн хөтөлбөр үндэсний хэмжээнд 4 дэх удаагаа магадлан итгэмжлэгдэв.
- БУ-ын Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэгдэв.
- НББ-ын улсын XXI олимпиадад тэргүүн байр эзлэж, үнэмлэхүй амжилт тогтоов.
- "Мандах-2019" ОУЭШХ 4 дэх удаа зохион байгуулав.

2018 он

- Үндэсний хэмжээнд 4 дэх удаагаа магадлан итгэмжлэгдэв.
- Мэдээлэл технологийн бүрэлдэхүүн сургуультай болж өргөжив.
- Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн цогцолбор Шинэ хичээлийн байрыг ашиглалтад оруулав.
- "2018 ОНЫ ОНЦЛОХ БАЙГУУЛЛАГА" /Дэлхийн бизнесийн нэгдсэн холбоо/.
- "2018 ОНЫ ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" МНСК Докторын хөтөлбөр нээв.
- Швейцарын Холбооны Улсын Эдийн засаг, технологийн сургуультай хамтарсан Хос диплом олгох хөтөлбөрөөр анхны төгсөлт хийв.



2017 он

- Мандах Их Сургууль нэртэй боллоо.
- Чанарын удирдлагын ISO9001:2015 стандартыг хувийн их дээд сургуулиудаас анх удаа нэвтрүүлэв.
- Европын Бизнес Ассамблейн бүс нутгийн шилдэг байгууллагаар шалгарлаа.
- "Мандах-2017" ОУЭШХ 3 дахь удаа зохион байгуулав.
- Статистикийн улсын олимпиадыг санаачлан зохион байгуулав.



2021 он

- "Ахисан түвшний сургууль"
- "Нягтлан бодох бүртгэлийн сургууль"
- "Инженер эдийн засгийн сургууль"-уудыг байгуулав.
- Мандах Лицей ахлах сургууль анхны элсэлтээ авлаа.
- "Татварын бүртгэл 2021" улсын олимпиадад Нягтлан бодогч, татварын улсын байцаагчийн ангилалд Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн ахлах багш М.Энхсүрэн Тэргүүн байр, багш Б.Ганбагана Гутгаар байрт шалгарлаа.
- Мандах Их Сургууль "Ээлтэй байгууллага 2021"-ээр тодорлоо.
- Мэдээлэл технологийн сургуулийн багш, оюутнууд хамтран хэлд орж байгаа бяцхан үрс үг сурахад зориулагдсан "Хүүхэд" апп бүтээсэн.




2022 он

- Мандах их сургуулийн 30 жилийн ой тохиов.
- Номын сангийн шинэ байр ашиглалтад оров.
- Сургуулийн захирал Г.Нанжид Монгол Улсын Гавьяат багш болов.
- НББ-ийн Улсын XXIII олимпиадад Мандах их сургууль тэргүүлээ.
- Тохочу их сургуулийн ЕМЕХ оюутан солилцооны хөтөлбөрт оюутнууд хамрагдав.
- Мандах их сургууль болон Швейцарын холбооны улсын Эдийн засаг, Технологийн их сургуультай хамтарсан хос диплом олгох хөтөлбөрийн 4 дэх төгсөлт боллоо.
- "Дижитал шилжилт ба тогтвортой хөгжил" олон улсын эрдэм шинжилгээний 5 дахь хурал хийгдэв.
- Инженерийн хөтөлбөрийн анхны диплом хамгаалалт боллоо.

2023 он

- НББ-ийн улсын 24 дүгээр олимпиадад Мандах их сургууль 13 дэх удаагаа тэргүүлээ.
- Санхүү менежментийн улсын олимпиадад "Дэд байр"-т шалгарав.
- Олон улсын Бизнес кейс тэмцээнд "Тусгай байр"-т шалгарав.
- "Инженерчлэлийн эдийн засаг" улсын нээлттэй III олимпиадад "Тусгай байр"-т шалгарав.
- "Программ хангамж"-ийн бакалаврын хөтөлбөр магадлан итгэмжлэгдэж гэрчилгээг хүлээн авав.

МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУД



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН УДИРДЛАГА

1. Захиргааны зөвлөлийн гишүүд

№	Албан тушаал	Овог нэр	Цол, зэрэг	Е-mail хаяг
1	Эрдмийн Зөвлөлийн дарга, Ректор	Г.Нанжид	Профессор	nanjid@mandakh.edu.mn
2	Эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор	Л.Энх-Амгалан	Доктор /Ph.D/, профессор	enkh@mandakh.edu.mn
3	Сургалт эрхэлсэн проректор	Ч.Төрбадрах	Доктор /Ph.D/, профессор	turbadrakh@mandakh.edu.mn
4	Санхүү эрхэлсэн проректор	С.Энхтүвшин	Магистр	enkhtuvshin@mandakh.edu.mn
5	Стратеги, хөгжлийн бодлого эрхэлсэн проректор	С.Энхтуяа	Дэд профессор	tuya@mandakh.edu.mn
6	Ахисан түвшний сургуулийн захирал	О.Бурмаа	Доктор /Ph.D/, дэд профессор	burmaa.o@mandakh.edu.mn
7	Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн захирал	Х.Нямбаяр	Дэд профессор	nyambayar@mandakh.edu.mn
8	Мэдээллийн технологийн сургуулийн захирал	Ө.Ганзориг	Магистр	ganzoo@mandakh.edu.mn
9	Ерөнхий нягтлан бодогч	Г.Эрдэнээ	Мэргэшсэн нягтлан бодогч	erdenee@mandakh.edu.mn
10	Сургалтын албаны дарга	С.Энхзаяа	Дэд профессор	enkhzaya@mandakh.edu.mn
11	Чанарын удирдлага, зохицуулалтын албаны дарга	П.Болормаа	Магистр, ахлах багш	bolormaa.p@mandakh.edu.mn

МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ЧАНАР МЕНЕЖМЕНТИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Мандах Их сургууль чанар менежментийн тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилго тавьж тууштай ажилласнаар 2017 оны 12-р сарын 25-нд хэрэгжүүлэгч байгууллага болж гэрчилгээг хүлээн авсан. Улмаар Боловсролын байгууллага менежментийн тогтолцоо ISO21001:2018 олон улсын стандартыг 2022 оны 6-р сарын 29-нд батламжийг гардан авсан Монгол улсын анхны боловсролын байгууллага болсон.

Мандах ИС-нь олон улсын стандартын санал болгосон менежментийн дараах аргуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

180 21001:2018 олон улсын стандартыг хэрэгжүүлж буй байгууллага нь менежментийн тогтолцооны амин чухал арга, хэрэгсэл болох **үйл явцын арга, эрсдэлд суурилсан сэтгэлгээний арга, тасралтгүй сайжруулалтын PDCA** (Төлөвлө-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул) мөчлөгийн арга хэрэглэснээр үйл явцыг хангалттай нөөц, зохих удирдлагаар хангах, тасралтгүй сайжруулах боломжийг тодорхойлж, улмаар хэрэгжүүлэх бололцоотой болсон.

Үйл явцын арга: Харилцан уялдаатай үйл явцуудыг тогтолцооны хүрээнд ойлгож, удирдах. Энэ хандлага нь тогтолцооны үйл явцуудын харилцан уялдаа, харилцан хамаарлыг хянах нөхцөлийг бүрдүүлэх, улмаар байгууллагын гүйцэтгэлийг бүхэлд нь сайжруулах боломж олгодог.

(Байгууллагын чанарын бодлого ,стратегийн чиглэлд нийцсэн үр дүнд хүргэх зорилго бүхий үйл явцуудын харилцан үйлчлэл, уялдаа холбоо, тэдгээрийг байнга тодорхойлох, удирдах зэрэг үйл ажиллагаа)


Эрсдэлд суурилсан сэтгэлгээ нь байгууллагын үйл явц, ББМТ-г төлөвлөсөн үр дүнгээс хазайхад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, түүний сөрөг үр дагаврыг бууруулах, бий болсон боломжийг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх бололцоог олгоно. *(байгууллагын төлөв байдлыг судлах, төлөвлөх үедээ эрсдэлийг тооцох, үйл явцыг төлөвлөж хэрэгжүүлэхдээ эрсдэлийг анхаарч түүнд чиглэсэн арга хэмжээг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.)*

Төлөвлөсөн үр дүнд хүргэх таатай нөхцөл нь: тухайлбал суралцагч болон бусад үр шим хүртэгчдийг татах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, хохирлыг бууруулах, эсвэл бүтээмжийг дээшлүүлэх бололцоо олгож буй байдал нь боломжийг бий болгоно. Эрсдэл нь тодорхой бус байдлын үр дүн ба ийм тодорхой бус байдал нь эерэг ч, сөрөг ч байж болно. Эрсдэлээс гарах эерэг өөрчлөлт нь боломж бий болгох боловч эрсдэлийн эерэг үр дүн бүр боломж авч ирдэггүй.

Тасралтгүй сайжруулалтын мөчлөг -PDCA (P-Төлөвлө, D-Гүйцэтгэ, C-Шалга, A- Сайжруул)- нь байгууллагын үйл явцыг хангалттай нөөц, зохих удирдлагаар хангах, мөн сайжруулах боломжийг тодорхойлж, хэрэгжүүлэх бололцоог олгоно.



ISO СТАНДАРТЫН БҮТЭЦ



Энэхүү баримт бичиг нь Мандах их Сургуулийн Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо 18021001:2018 стандартыг хэрэгжүүлэх удирдамж болно. Мандах их сургуулийн менежментийн тогтолцооны зураглал:





НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ

Мандах Их Сургууль нь 2001 оноос магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж магистрын сургалт, судалгааны ажлыг эхлүүлсэн ба 2003 онд анхны төгсөлтөө хийснээс хойш 26 удаа төгсөлт хийгээд байна. Энэ хугацаанд магистрын хөтөлбөрийн дэд хороог байгуулан, магистрын хөтөлбөрийн шинэчлэл сайжруулалтыг тасралтгүй хийснээр 2018 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлүүлсэн. 2018 оноос бизнесийн удирдлагын докторын хөтөлбөрийг нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, эдийн засаг, менежментийн чиглэлээр хэрэгжүүлж байна.

Тус сургууль 2015 оноос цахим сургалтын системээ ашиглан магистрын хөтөлбөрийн сургалтаа цахим болон танхим хосолсон хэлбэрээр явуулж байна. Магистр, докторын сургалт, судалгааны ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс сургуулийн удирдах зөвлөлийн шийдвэрээр 2021 онд Ахисан түвшний сургууль байгуулан, захирлаар доктор, дэд профессор, шилдэг судлаач багш С. Цолмон ажиллаж байсан бөгөөд 2023 онд захирлаар доктор, дэд профессор О.Бурмаа ажиллаж байна.

Ахисан түвшний сургууль нь магистр, докторын сургалт, судалгааны хөтөлбөрийг сайжруулах, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх, магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулах, ахисан түвшинд мэргэжил дээшлүүлэх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, магистрант, докторантын сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Цаашид бид Сургалт-судалгааны их сургууль болох зорилтоо хэрэгжүүлэх үүднээс магистр, докторын хөтөлбөрөөс гадна төрөл бүрийн төсөлт судалгааны ажлын цар хүрээг тэлэх, ахисан түвшинд мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах зэрэг өргөн цар хүрээнд ажиллах шаардлагын үүднээс сургуулийн, Удирдах зөвлөлийн 2021 оны 03 сарын 05-ны 01-р тогтоолоор магистр, докторын албыг Ахисан түвшний сургууль гэж өөрийн Мандах Их Сургуулийн бүтцийн сургууль болгосон билээ. Тус сургуулийн зорилгыг дараах байдлаар тодорхойлсон болно.

ЗОРИЛГО

Ахисан түвшний сургуулийн зорилго нь магистр, докторын сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг явуулж, шинжлэх ухаан, технологийн шинэ ололт амжилт, инновацыг практикт нэвтрүүлэх арга замыг тодорхойлох мэдлэг, чадвартай үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх судлаачдыг бэлтгэх

ЗОРИЛТУУД

ЗОРИЛТ 01. Танхим болон цахим сургалт хосолсон магистр, докторын сургалтыг чанартай явуулж, сургалт, судалгаа, практикийн гурвалсан холбоог хөгжүүлэх

ЗОРИЛТ 02. Ахисан түвшний мэргэжил дээшлүүлэх болон магистр, докторын хөтөлбөрт суралцах суралцагсдын тоог нэмэгдүүлэх, элсэлт, сургалт, төгсөгчийн үйл ажиллагааг зохион байгуулах

ЗОРИЛТ 03. Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага болон оролцогч талуудын хэрэгцээ, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж, магадлан итгэмжлүүлэх

ЗОРИЛТ 04. Ахисан түвшний сургуулийн эрлэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний их хурал, семинарыг зохион байгуулах

Энэхүү зорилго, зорилтынхоо хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлж байна.

- 2015 оноос эхэлсэн магистрантуудын эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулж ирсэн.
- Шилдэг судлаач магистрантыг шалгаруулан сургалтын төлбөрийг нь тодорхой хувиар хөнгөлөн тэтгэлэгт хамруулдаг.
- Докторантурт сурч байгаа багш нарыг идэвхжүүлэх, судалгааны ажлыг чанаржуулах үүднээс судалгааны ажлын хэлэлцүүлгийг тогтмол хийдэг Өнөөгийн байдлаар манай 26 багш өөрийн сургуулийн болон бусад сургуулиудын докторантурт сурч байна.
- Эдгээр докторантуудаас шалгаруулан судалгааны ажлын грант олгодог бөгөөд 2019 онд анхны грантыг багш Б.Сайнжаргал, 2020 онд багш С.Мөнхцэцэг, 2021 онд багш Л.Дансранбавуу, 2022 онд Ж.Гантулга нар хүртсэн.

Магистр, докторын хөтөлбөрийн онцлог, давуу тал

1. Цахим болон танхим хосолсон үр дүнд суурилсан сургалтыг явуулна
2. Салбартаа тэргүүлэгч, гадаад болон дотоодын их сургуульд эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн багш, боловсон хүчинтэй
3. Гадаадын их сургуулийн хамтарсан болон хос диплом олгох хөтөлбөрт хамрагдах боломжтой
4. Орчин үеийн бизнес, санхүү, банкны технологид (Fintech, digital finance, blockchain, big data) суурилсан мэдлэг, чадвар эзэмшүүлнэ
5. Судалгаанд суурилсан шийдвэр гаргах арга зүйг эзэмшүүлнэ

1.1 АТС-ИЙН ЭРДЭМТЭН, БАГШ НАР

№	Албан тушаал	Овог нэр	Цол, зэрэг
1	Эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор	Л.Энх-Амгалан	Доктор /Ph.D/, Профессор
2	Сургалт эрхэлсэн проректор	Ч.Төрбадрах	Доктор /Ph.D/, дэд Профессор
3	Бүртгэл шинжилгээний тэнхимийн зөвлөх профессор	Р.Батжаргал	Доктор /Ph.D/, Профессор
4	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн профессор	Б.Нацагдорж	Доктор /Ph.D/, Профессор
5	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн профессор	Б.Асралт	Доктор /Ph.D/, Профессор
6	Бүртгэл шинжилгээний тэнхимийн профессор	Г.Алтанзаяа	Доктор /Ph.D/, Профессор
7	Бүртгэл шинжилгээний тэнхимийн зөвлөх профессор	Б.Аюуш	Доктор /Ph.D/, Профессор
8	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн зөвлөх профессор	Д.Бадарч	Доктор /Ph.D/, Профессор
9	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн зөвлөх профессор	Т.Нарантуяа	Доктор /Ph.D/, Профессор


10	Ахисан түвшний сургуулийн захирал	О.Бурмаа	Доктор /Ph.D/, дэд Профессор
11	Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн зөвлөх профессор	Ц.Ядамсүрэн	Доктор /Ph.D/, дэд Профессор
12	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн зөвлөх профессор	Г.Билгээ	Доктор /Ph.D/, дэд Профессор
13	Гадаад хэлний тэнхимийн дэд профессор	С.Ганцэцэг	Доктор /Ph.D/, дэд Профессор
14	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн дэд профессор	С.Цолмон	Доктор /Ph.D/, дэд Профессор
15	Бүртгэл шинжилгээний тэнхимийн дэд профессор	А.Наранцэцэг	Доктор /Ph.D/, дэд Профессор
16	Дэд профессор	Ч.Чимэдсүрэн	Доктор /Ph.D/, дэд Профессор
17	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн эрхлэгч	Б.Сайнжаргал	Доктор /Ph.D/
18	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн ахлах багш	Д.Буяндэлгэр	Доктор /Ph.D/
19	Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч	Д.Түвшинжаргал	Доктор /Ph.D/
20	Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн дэд профессор	О.Баттуяа	Доктор /Ph.D/
21	Бүртгэл шинжилгээний тэнхимийн ахлах багш	Р.Дариймаа	Доктор /Ph.D/
22	Гадаад хэлний тэнхимийн эрхлэгч, ахлах багш	Б.Энхзул	Доктор /Ph.D/
23	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн ахлах багш	Л.Гүнжаргал	Доктор /Ph.D/
24	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш	Б.Баярсайхан	Доктор /Ph.D/
25	Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн ахлах багш	П.Гантуяа	Доктор /Ph.D/

Эрдмийн зөвлөлийн гишүүд


№	Албан тушаал	Овог нэр	Цол, зэрэг
1	Эрдмийн Зөвлөлийн дарга, Ректор	Г.Нанжид	Профессор
2	Эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор	Л.Энх-Амгалан	Доктор /Ph.D/, Профессор
3	Сургалт эрхэлсэн проректор	Ч.Төрбадрах	Доктор /Ph.D/, дэд Профессор
4	Бүртгэл шинжилгээний тэнхимийн зөвлөх профессор	Р.Батжаргал	Доктор /Ph.D/, Профессор
5	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн профессор	Б.Нацагдорж	Доктор /Ph.D/, Профессор
6	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн профессор	Б.Асралт	Доктор /Ph.D/, Профессор
7	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн зөвлөх профессор	Д.Бадарч	Доктор /Ph.D/, Профессор
8	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн зөвлөх профессор	Г.Билгээ	Доктор /Ph.D/, дэд Профессор
9	Гадаад хэлний тэнхимийн дэд профессор	С.Ганцэцэг	Доктор /Ph.D/, дэд Профессор
10	Эдийн засаг, бизнесийн тэнхимийн дэд профессор	С.Цолмон	Доктор /Ph.D/, дэд Профессор
11	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд Профессор	А.Наранцэцэг	Доктор /Ph.D/, дэд Профессор
12	Сангийн яамны НББ-ийн газрын дарга	Б.Болормаа	Доктор /Ph.D/
13	Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч	Д.Түвшинжаргал	Доктор /Ph.D/

Эрдмийн зөвлөлийн гишүүд




Г.Нанжид
МУ-ын гавьяат багш Профессор
 nanjid@mandakh.edu.mn




Р.Батжаргал
Доктор /Ph.D./, Профессор
 batjargal@mandakh.edu.mn



Ч.Төрбадрах
Доктор /Ph.D./, Профессор
 turbadrakh@mandakh.edu.mn




Л.Энх-Амгалан
Доктор /Ph.D./, Профессор
 enkh@mandakh.edu.mn




Г.Билгээ
Доктор /Ph.D./, дэд Профессор
 bilgee.g@mandakh.edu.mn




С.Ганцэцэг
Доктор /Ph.D./, дэд Профессор
 gantsetseg@mandakh.edu.mn




С.Цолмон
Доктор /Ph.D./, дэд Профессор
 tsolmon@mandakh.edu.mn




А.Наранцэцэг
Доктор /Ph.D./, дэд Профессор
 narantsetseg@mandakh.edu.mn




Б.Асралт
Доктор /Ph.D./, Профессор
 asralt@mandakh.edu.mn




Д.Түвшинжаргал
Доктор /Ph.D./
 tuvshinjargal@mandakh.edu.mn




Д.Бадарч
Доктор /Ph.D./, Профессор
 d.badarch@dbm.mn



Б.Нацагдорж
Доктор /Ph.D./, Профессор
 natsagdorj@mandakh.edu.mn



Б.Болормаа
Доктор /Ph.D./
 bolormaa_bu@mof.gov.mn

Ахисан түвшний сургуулийн хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанли

Намрын улирал

- 2023.08.14-19
 - Эчнээ хөтөлбөрийн нэмэлт элсэлтийн бүртгэл
- 2023.08.26
 - Сургалтын үйл ажиллагааны чиглүүлэх сургалт / 1 курс /
- 2023.08.19
 - Эчнээ 2 курсын хичээл эхэлнэ
- 2023.08.28 – 2023.12.15
 - Намрын улирлын хичээлийн өдрүүд
- 2023.08.23 -08.25
 - 1, 2, 3, 4 курсын хичээл болон багш сонголт хийх систем нээгдэнэ
- 2023.08.26 Бямба гариг
 - Эчнээ 1 курсын хичээл эхэлнэ
- 2023.08.16-09.01 /Сургалтын алба /
 - Шинээр элсэгчидтэй суралцах гэрээ байгуулна / бакалаврын өдрийн 1 курс /
- 2023. 09 .04 Даваа гариг
 - Магистрын хөтөлбөрийн элсэлтийн шалгалт
- 2023. 09 .01-24
 - Докторын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл
- 2023. 09 .16 Бямба гариг
 - Магистрын хөтөлбөрийн хичээл эхэлнэ
- 2023.10.23-29 / 0 долоо хоног /
 - Явцын шалгалт 1/
- 2023.11.14 /Мягмар гариг. Бүх нийтийн амралтын өдөр/
 - Их эзэн Чингис хааны өдөр буюу “Монгол бахархал”-ын өдөр
- 2023 . 11 . 26 Ням гариг
 - Улс тунхагласан өдөр
- 2023. 12 сарын 11-15
 - Магистрын төгсөлтийн нэгдсэн шалгалт
- 2023.12.11
 - 4 курсын оюутнуудаас олон улсын хөндлөнгийн үнэлгээний / Peregrine / шалгалт
- 2023.11.27-12.30
 - Төгсөх 4-р түвшний оюутнуудын кейс дадлага
- 2023. 12 сарын 23 Бямба гариг
 - Магистр хөтөлбөрийн диплом гардуулах ёслолын ажиллагаа
- 2023. 12 .16 -2021.12. 30
 - Намрын улирлын 30 онооны шалгалтын өдрүүд
- 2023.12.29 Баасан гариг
 - Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр /бүх нийтийн амралтын өдөр /
- 2024.01 .01 Даваа гариг
 - Шинэ оны эхний өдөр / бүх нийтийн амралтын өдөр /
- 2024. 01.04-05
 - Англи хэлний төгсөлтийн шалгалт / 3 курс /
- 2024.01.11-13 / Чанарын үнэлгээний хороо /
 - Оюутны дүнг сургалтын системд оруулсан байдалд хөндлөнгийн хяналт хийнэ / бүх хөтөлбөр /

Хаврын улирал

- 2024.01.04-05
 - Үйлдвэрлэлийн дадлагын удирдамж тараана /4-р курс/
- 2024.01.08-02.09
 - Үйлдвэрлэлийн дадлага / 4 курс /
- 2024.01.22- 5.10
 - Хаврын улирлын хичээлийн өдрүүд
- 2024.02. 09 -11 Баасан, Бямба гариг
 - Цагаан сар
- 2024.02.26- 04.19
 - 4-р курсын хичээл / 8 долоо хоног/
- 2024.03.04-05
 - Үйлдвэрлэлийн дадлагын тайлан хураана
 - Судалгааны ажил хураана / 4 курс /
- 2024.03.06-03.12
 - Үйлдвэрлэлийн тайлан хамгаална / 4 курс /
- 2024.03.08 Баасан гариг
 - Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр / бүх нийтийн амралтын өдөр /
- 2024.03.11-03.16
 - IX долоо хоног / Явцын сорил 1 /
- 2024.04.03
 - Бакалаврын дипломын ажлын урьдчилсан хамгаалалт /4 курс /
- 2024.04.29-05.08
 - Тойм лекц / төгсөлтийн шалгалтын бэлтгэл 4 курс /
- 2024.05.08
 - Бакалаврын дипломын хамгаалалт / 4 курс /
- 2024.05.09-05.10
 - Төгсөлтийн нэгдсэн шалгалт / 4 курс /
- 2024.04.29-05.10
 - XIY,XV,XVI долоо хоног / Явцын сорил 2/
- 2024.05. 23-05.24
 - Төгсөгчдөд диплом гардуулах ёслолын ажиллагаа 3
- 2024.5.13- 05.31
 - Хаврын улирлын 30 онооны шалгалтын өдрүүд
- 2024.06 .01 Бямба гариг
 - Хүүхдийн баяр /бүх нийтийн амралтын өдөр/
- 2024.06 .12
 - Сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилийн тайлангийн хурал
- 2024.06 .08
 - Эчнээ хөтөлбөрийн 2 курсын хичээл дуусна
- 2024.06. 17-06.18
 - НББ, аудит, шинжилгээ хичээлийн төгсөлтийн шалгалт / Эчнээ хөтөлбөрийн төгсөх курс /
- 2024. 06 .24
 - Диплом гардуулах ёслолын ажиллагаа / эчнээ хөтөлбөр /

Ахисан түвшний сургууль нь хичээлийн жилд нийт магистрант нартай улирал бүр сургалтын хөтөлбөр болон ЭША-ын талаар санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. Мөн хичээлийн жилийн турш нийт 5 удаа суралцагчийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын хэлэлцүүлгийг хийдэг.



Ахисан түвшний сургуулийн хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүн


Хорооны нэр	НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО	САНХҮҮ, БАНК, ДААТГАЛЫН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО	БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО	БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО
Дарга	А. Наранцэцэг	С. Цолмон	Б. Сайнжаргал	О.Бурмаа
Гишүүд	Л.Энх-Амгалан	Ч. Төрбадрах	Ч. Төрбадрах	Б.Сайнжаргал
	Г.Алтанзаяа	Ц.Нацагдорж	Д.Буяндэлгэр	Л.Энх-Амгалан
	Х.Нямбаяр	Л.Гүнжаргал	Т.Баярсайхан	Б.Асралт
				А.Наранцэцэг
Нарийн бичиг	Ц. Одгарав	Ж.Гантулга	Т.Намуун	С.Цолмон
				Л.Гүнжаргал

Магистр, докторын хөтөлбөрийн олон улсын жишигт хүргэн сайжруулахын тулд “Хөтөлбөрийн дэд хороо”-ууд ажилладаг бөгөөд одоогоор магистрын хөтөлбөрийн 3, докторын хөтөлбөрийн 1 дэд хороо ажиллаж байна.

1.2 МАНДАХ ЭРДЭМ СЭТГҮҮЛ

Товч танилцуулга

Сэтгүүлийн зорилго. Эрдэмтэн багш, судлаач, мэргэжилтнүүдийн судалгаа шинжилгээний бүтээл болон дэвшүүлж буй шинэ санаа, инновацыг нийтэд хүртээл болгох, сурталчлах индэр нь байх болно. Энэхүү сэтгүүл нь жилд 2 удаа тогтмол хэвлэгдэх бөгөөд бүртгэл, санхүү, эдийн засаг, хүмүүнлэг, боловсрол судлал, инженер, мэдээллийн технологийн чиглэлийн эрдэм шинжилгээний бүтээлийг нийтэлнэ.



1.3 НОМЫН САН

Эрхэм зорилго: Уншигчдад хэрэгцээт мэдээлэл, ном сурах бичгээр бүрэн хангахуйц чанартай сан хөмрөгтэй, шинэлэг үйлчилгээ, чадварлаг боловсон хүчин бүхий мэдээллийн төв болох.

Манай номын сан нь 1992 онд Хүнсний Техник Мэргэжлийн сургуулийн байранд багш, ажилчдын хандивласан 300 гаруй номтой, 1 номын санчтайгаар анх үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй.

1998 онд сургууль хичээлийн шинэ байртай болж, 1 давхартаа 160м² талбайтай, 100 суудал бүхий номын сантай болсон.

Тус сургууль нь 2018 онд олон улсын стандарт бүхий хичээлийн шинэ байрыг ашиглалтад оруулж 560м² талбайтай, 433 суудал бүхий танхимтай номын санг байгуулсан.

2022 онд 1296м² талбайтай 450 суудал бүхий 5 давхар бие даасан барилгатай болсон.



28000 гаруй ном сурах бичиг, 300 гаруй эрдэм шинжилгээ судалгааны ажил, 400 гаруй цахим хэлбэрийн ном, Монгол, Англи, Япон, Орос хэл дээрх номын фондтойгоор багш оюутнуудад үйлчилж байна

Уншлагын танхимууд

- Чөлөөт сонголттой уншлагын танхим
- E-уншлагын танхим
- Багаар ажиллах танхим
- Ганцаарчилсан уншлагын танхим
- Эрдэм шинжилгээ судалгааны уншлагын танхим
- Оюутны хөгжлийн төв


Үйлчилгээний төрлүүд

- ✓ Чөлөөт сонголттой уншлагын фонд
- ✓ Гэрээр ном олгох үйлчилгээ
- ✓ Тогтмол хэвлэлийн үйлчилгээ
- ✓ Хэвлэх үйлчилгээ
- ✓ Цахим мэдээллийн сангийн үйлчилгээ
- ✓ Лавлагаа мэдээллийн үйлчилгээ


ЧӨЛӨӨТ СОНГОЛТТОЙ УНШЛАГЫН ТАНХИМ




УНШЛАГЫН А, Б ТАНХИМ /2 БОЛОН 3 ДАВХАРТ/




БАГААР АЖИЛЛАХ ӨРӨӨ /4 ДАВХАРТ/



ГАНЦААРЧИЛСАН УНШЛАГЫН ТАНХИМ /4ДАВХАРТ /



Е СУДАЛГААНЫ ТАНХИМ



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ- СУДАЛГААНЫ ТАНХИМ



ОЮУТАН АМРАХ ӨРӨӨ



ОЮУТАН ХӨГЖЛИЙН ТӨВ




2017 онд шинээр гарсан орчин үеийн үүлэн технологи дээр суурилсан LIB4U программын шинэчилсэн хувилбарыг номын сандаа ашиглаж эхэлснээр электрон номын сан болон электрон каталог байгуулан интернэтээр уншигчдад ном ашиглуулах, номын сангийн хөмрөгт байх ном, тогтмол хэвлэл, эрдмийн ажил зэрэг материалуудыг бүртгэх, зураасан кодын тусламжтайгаар номын сангийн үйлчилгээ, тооллого хийх , номын сантай холбоотой төрөл бүрийн тайлан, статистик мэдээллээр бүрэн хангах боломжтой, дурын компьютер, таблет, гар утас зэрэг ухаалаг төхөөрөмжүүд дээр ажиллах боломжтой болсон.

2022 оны 10 сараас эхлэн Номын сан нь бие даасан 5-н давхар байртай болж, давхар бүртгээ уншигчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан чөлөөт сонголтоор,е-уншлагын танхимаар, гэрээр ном олгох, хэрэглэгч төвтэй цахим үйлчилгээ, Эрдэм шинжилгээ судалгаа гэсэн 5н үндсэн чиглэлээр үйлчилгээг явуулж эхэллээ.

Мандах Их Сургуулийн номын сан нь 350 м.кв талбай, 28.000 орчим номтой. Нийт 215 суудалтай, 5 номын санчтай, 7 хоногийн 6 өдөр, 2 ээлжээр үйлчилнэ.

LIB4U Virsion 1.9 программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаагаас гадна интернэтэд холбогдсон компьютероор дэлхийн аль ч цэгээс хайлт хийн хэрэгцээтэй ном, сурах бичиг, гарын авлагыг олж унших боломжтой. Гадаадын 9 номын санг ашиглах эрхтэй.

Номын сангийн үйлчилгээ, орчны MNS 5247:2007 стандарт нэвтрүүлэн ажиллаж байна.




<http://mandakh.Lib4U.net> Электрон каталогийн хаяг:


Хэрэглэгчийн хэсэг нь нэвтрэх нэр, нууц үг гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

-Нэвтрэх нэр гэсэн хэсэгт оюутны кодыг бичнэ.

-Нууц үг гэсэн хэсэгт регистрийн дугаарын зөвхөн 8 оронтой тоог бичнэ.



Хэрэглэгчээр нэвтэрсэн тохиолдол электрон хувилбарт байгаа ном, сурах бичиг, судалгааны ажлуудыг онлайнаар унших боломжтой. Жишээ нь: өөрийн унших материалын Веб хувилбар гэсэн хэсгийг дарж үзнэ.



1.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЛАБОРАТОРИ СУРГАЛТЫН ОРЧИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Тус лаборатори /А305 тоот/-т бизнесийн чиглэлийн хөтөлбөрүүдийн мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийг судалж, танхимаар олж авсан мэдлэгээ практикт буулгах дадлагуудыг лабораторид хийж бататгадаг. Энэхүү лабораторид компьютерын хэрэглээний Microsoft –ийн үндсэн программуудаас гадна нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, бизнесийн удирдлага, маркетингийн мэргэжлийн дараах программууд дээр сургалт, судалгааны ажил гүйцэтгэх боломжтой. Үүнд:



- Diamond 5.0

Тус программыг Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг томоохон групп компаниуд, худалдаа үйлдвэрлэл, зочид буудал ресторан, сургууль, барилга, уул уурхай гэх мэт олон компаниуд өргөнөөр ашиглаж байна.

Энэхүү программыг нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр сурч байгаа оюутнуудад нийт 64 цагийн хичээлээр заадаг ба ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайлангуудыг программ ашиглан бүртгэж сурна. Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн систем хичээл нь оюутанд мэргэжлийн суурь хичээлээ бататгах боломжийг олгодог илүү практик ач холбогдолтой хичээл юм.



- Artlab cloud system

Тус программыг төгсөх курсийн оюутнууд кейс дадлагын хүрээнд судалдаг бөгөөд орчин үед техник технологийн хөгжлийг дагаад суурин программын хэрэглээ буурч, үүлэн технологид суурилсан санхүүгийн программын хэрэгцээ нэмэгдэж байгаа билээ. Иймээс бид төгсөгчдөдөө онлайнд ажиллах боломжтой дээрх программыг заадаг. Манай улсад ийм төрлийн программын тоо нэмэгдэж байгаа бөгөөд санхүүгийн программын ажиллах суурь зарчим адил учраас аль нэг программ дээр ажиллах мэдлэг, ур чадвартай байхад бусад программтай төвөггүй ажиллах боломжтой.




- Power BI

Уг программ байгууллагын санхүүгийн ялгаатай өгөгдлийг олон эх үүсвэрээс татан холбоход тусалж, өгөгдлийг нэг загварт хувиргаж, цэвэрлэж, диаграмм эсвэл график үүсгэн дүрслэх боломжтой болгодог. Томоохон байгууллагууд санхүүгийн үйл ажиллагаандаа хэрэглэх болсон.



- R

Статистик тооцоолол, графикийн хэл гэж тодорхойлогддог тус программ нь санхүү, эдийн засгийн судалгаанд, тоон мэдээлэлд боловсруулалт хийн, үр дүн гаргаж авахад ихээр ашиглагддаг.



- Matlab

Аж үйлдвэр, эрдэм шинжилгээний мөн санхүүгийн салбарт гүнзгий сургалт, машин сургалт, дохио боловсруулах, харилцаа холбоо, дүрс, видео боловсруулах, хяналтын систем, туршилт, хэмжилт, санхүүгийн тооцоолол зэрэгт өргөн ашиглагддаг.



- E-Views

Хугацаан цуваа, хөндлөн огтлол, хавтан зэрэг олон хэлбэрийн тоон мэдээлэлд ерөнхий статистик шинжилгээ хийх, эконометрик шинжилгээ хийж үр дүнг боловсруулах зориулалттай.



- SPSS

Тоон хэлбэрээр бус нийгмийн ухааны мэдээллийг багцлах, нарийн төвөгтэй статистик шинжилгээ хийж, үр дүнг гарган авах зориулалттай.

1.5 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Мандах их сургуулийн хамтын ажиллагаа

Мандах их сургууль нь стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд олон улсын болон үндэсний байгууллагуудтай багш, ажилтан, оюутнуудын мэргэжил дээшлүүлэх, сургалт, судалгааны ажлыг үр өгөөжтэй болгох чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж байна.

Өнөөдрийн байдлаар тус сургууль нь төрийн болон төрийн бус 60 орчим байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, судалгаа, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлэг хийж, харилцан туршлагаа хуваалцах, оюутны дадлага хийх, мэргэжлийн чиглэлийн сургалт болон уралдаан тэмцээн зохион байгуулах, оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургуулийн өсөн дээшлэх нэг түлхэц бол гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх явдал юм. Мандах их сургууль нь орчин үеийн хандлага, хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд гадаадын их, дээд сургуулиудтай түншлэлийн харилцаа тогтоож, хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Одоогийн байдлаар Мандах их сургууль 20 гаруй гадаадын их дээд сургуулиудтай эрдэм шинжилгээ, судалгаа, багш ажилтнууд, оюутан солилцоо болон хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг.

Мандах их сургууль 2017 оноос эхлэн Швейцарын Эдийн засаг, технологийн сургуультай хамтран хос диплом олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор 3 дахь удаагийн төгсөлтөө хийгээд байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтран ажиллах үйл ажиллагааны нэгээхэн хэсэг нь олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хамтрагч байгууллагууд төлөөлөгчдөө оролцуулж, илтгэл хэлэлцүүлж, харилцан мэдлэгээ хуваалцах үйл ажиллагаа байдаг. Мандах их сургууль 2012 оноос эхлэн хоёр жил тутам олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг гадаадын их дээд сургуулиудын эрдэмтэн багш, профессоруудыг урьж оролцуулдаг уламжлал бий болсон бөгөөд

эдүгээ 4 дөх удаагийн хурлыг зохион байгуулаад байна. Энэхүү эрдэм шинжилгээний хуралд олон улс орноос төлөөлөгчид хүрэлцэн ирж, өөрсдийн илтгэлээ тавьж, шинэ мэдлэг, мэдээллээ хуваалцан, цаашид хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах тухайгаа харилцан ярилцаж, хэлэлцдэг.

2012 оноос эхлэн АНУ-ын олон улсын магадлан итгэмжлэх байгууллагатай (ACBSP) хамтран ажиллаж, тус байгууллагаас зөвлөмж зөвлөгөө авч, хэрэгжүүлсний үр дүнд олон улсын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг ханган, улмаар 2014 оны 8-р сарын 29-нд сургууль болон хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлж, ACBSP байгууллагаас албан ёсоор батламжаа гардан авсан.

Түүнчлэн чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага дээрээ тулгуурлан боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO21001:2018 стандартыг монголын боловсролын байгууллагуудаас анх удаа хэрэгжүүлэхээр зорилго тавьсны дагуу энэтхэг улсын ISO стандартын баталгаажуулалтын IRCLASS байгууллагатай нягт хамтран ажиллаж, өгсөн санал зөвлөмжийг авч амжилттай хэрэгжүүлснээр тус стандартыг бүрэн хэрэгжүүлэх чадамжтай болохыг баталгаажуулсан албан ёсны гэрчилгээг 2020 оны 9-р сард хүлээн авсан юм.



Хамтран ажилладаг сургуулиуд

№	Сургуулийн нэр	Сургуулийн лого	Хэрэгжүүлэх хөтөлбөр	Хамтрах чиглэл
1	Тайландын Махасарахам их сургуулийн Бизнесийн сургууль		Оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, бизнес
2	Японы Тохоку их сургуулийн Эдийн засаг, Менежментийн их сургууль		Оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, бизнес
3	БНСУ-ын Кёнги их сургууль		Бакалаврын болон Магистрын Оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, санхүү, бизнес, менежмент
4	БНСУ-ын Күүмин их сургууль		Бакалаврын болон Магистрын Оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, санхүү, бизнес, менежмент
5	АНУ-ын Виржиниагийн Олон улсын их сургууль		Бакалаврын болон магистрын оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, санхүү, бизнес, менежмент, олон улс судлал
6	Швейцарын Эдийн засаг, технологийн их сургууль		Хос диплом олгох хөтөлбөр /Бакалавр, магистр/	НББ, санхүү, банк, эдийн засаг, маркетинг, бизнесийн удирдлага, мэдээлэл технологи, бизнесийн удирдлага /доктор/
7	Казакстаны Кокшетау их сургууль		Бакалаврын хамтарсан хөтөлбөр	НББ, эдийн засаг, санхүү, бизнес, менежмент
8	БНСУ-ын Хандонг их сургууль		Хос диплом олгох хөтөлбөр	Эдийн засаг, бизнес, мэдээлэл технологи, инженер
9	Австралийн Southern Cross их сургууль		Бакалаврын болон магистрын оюутан солилцооны хөтөлбөр	Бакалаврын болон магистрын оюутан солилцооны хөтөлбөр

10	ОХУ-ын Москва хотын Мэдээлэл, холбооны их сургууль		Бакалаврын, магистрын, докторын оюутан солилцооны хөтөлбөр	Мэдээлэл технологи, инженерчлэл
11	Вьетнам улсын Бизнес, технологийн их сургууль		Бакалаврын, магистрын, докторын оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, бизнес, инженерчлэл
12	Тайваны ВуФенг их сургууль		3+1 хөтөлбөр	Механик инженер
13	Индонези улсын Стеком их сургууль		Бакалаврын, магистрын оюутан солилцооны хөтөлбөр	Мэдээлэл технологи, инженер эдийн засаг, компьютерын шинжлэх ухаан
14	Хойд Кипр улсын Зүүн Газар дундын тэнгисийн их сургууль		Бакалаврын оюутан солилцооны хөтөлбөр	Эдийн засаг, бизнес, механик-инженер, компьютер, мэдээлэл технологи
15	Ази, Номхон далайн орнуудын Олон улсын оюутан солилцооны UMAP хөтөлбөр		Гишүүн орнуудын хамтарсан хөтөлбөрүүд	Эдийн засаг, бизнес, санхүү, инженер, мэдээлэл технологи, соёл урлаг, хүмүүнлэг
16	АНУ-ын Махараши Олон улсын их сургууль		Магистрын хөтөлбөр	Мэдээлэл технологи
17	Грийнвич England Хөтөлбөр		Мэргэжлийн англи хэлний сертификат олгох хөтөлбөр	Мэргэжлийн англи хэл

1.6 АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛИАС ЗОХИОН БАЙГУУЛДАГ СУРГАЛТУУД

Ахисан түвшний сургуулиас зохион байгуулдаг эдийн засаг, бизнесийн чиглэлийн зэргийн бус сургалтууд нь хувь хүний насан туршийн боловсрол болон хөдөлмөрийн салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэн, төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хувь хүн болон бизнесийн байгууллагуудад зориулсан дараах сургалтуудыг Мандах ИС –ийн эрдэмтэн багш нараас гадна эдийн засаг, бизнесийн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн багш нартай хамтран зохион байгуулдаг. Үүнд:

Мэргэжлийн анхан шатны мэдлэг олгох

- Хувь хүний санхүүгийн сургалт
- Бизнесийн төсөл бичих сургалт
- Хөрөнгийн зах зээл дээр арилжаа хийх сургалт
- Теллер, банкны эдийн засагчийн анхан шатны сургалт
- Хүний нөөцийн менежерийн анхан шатны сургалт
- Нягтлангийн анхан шатны мэдлэг олгох сургалт

Мэргэжил дээшлүүлэх

- Удирдах албан тушаалтнуудад санхүүгийн мэдлэг олгох сургалт
- НББ –ийн ахисан шатны сургалт
- Компанийн засаглалын сургалт
- СТОУС –ийн сургалт
- Санхүүгийн шинжээч
- Судалгааны программын сургалт /SPSS, Eviews, STATA, R программ гэх мэт/
- Эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн сургалт
- Бизнесийн англи хэлний сургалт

Сургалтын онцлог, давуу тал

- Хөдөө орон нутаг болон гадаадаас сургалтад цахим хэлбэрээр хамрагдах боломжтой.
- Мэргэжлийн өндөр ур чадвар бүхий эрдэмтэн багш нар хичээл заана.
- Сургалтад ашиглах материал, гарын авлага үнэгүй дагалдана.
- Амжилттай суралцсан төгсөгчдөд Certificate олгоно.

ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА







1.7 ЦАХИМ СУРГАЛТЫГ АШИГЛАХ ЗААВАР

1. Сургалтын сайтыг ашиглахдаа та дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Таны компьютер интернэтэд холбогдсон байх
- Google Chrome, Mozilla firefox гэх мэт интернэт хөтөч программ таны компьютерт суусан байх
- Хичээлийг үзэж, судлахын тулд таны хэрэглэж буй интернэтийн хурд 1 Mbps ба түүнээс дээш хурдтай байх
- Компьютерын хүчин чадал P4 ба түүнээс дээш байх
- Windows 7 түүнээс хойших үеийн үйлдлийн систем бүхий компьютертой байх


2. Цахим сургалтын сайтад нэвтрэх болон сайтаас гарах

- Сургуулийн веб сайт болох <http://mandakh.edu.mn/> сайтаар орж ЦАХИМ СУРГАЛТЫН СИСТЕМ хэсэгт дарж систем рүү нэвтэрч орно.



Нэвтрэх нэр, Нууц үг: Сургалтын программд нэвтрэхийн тулд та сургуулийн зүгээс олгосон нэвтрэх эрхийг авсан байх шаардлагатай. Хэрэв та нэвтрэх эрхтэй бол интернэт хөтөч (Google Chrome, Mozilla Firefox, Opera гэх мэт) ашиглан программын хаягийн мөрөнд <http://online.mandakh.org/> хаяг руу орно. Холбогдсон бол сайтын баруун дээд буланд байх программын хэл солих “English (en)”, “Монгол (mn)” сонголтыг сонгож болно. Зураг 1


Зураг 1. Цахим сургалтын системийн нэвтрэх хэсэг



Дээрх холбоосоор нэвтэрсэн тохиолдолд дараах цонх харагдах бөгөөд багш, оюутан сургуулийн зүгээс өгсөн Нэр, Нууц үгээ ашиглан сайтад нэвтэрнэ.

- Нэвтрэх нэр (Username)
Нэвтрэх нэр нь оюутны кодоо оруулна. Жишээ нь: таны код AC22E001 бол оруулахдаа **ac22e001** гэж оруулна.
- Нууц үг (Password)
Нууц үг нь өөрийн регистрийн дугаарын сүүлийн 8 тоог оруулна. Жишээ нь: РД: AA98123101 бол оруулахдаа **98123101** гэж оруулна.
- Холбогдох товч (Log in)

Сайтаас гарах: Сайтад нэвтэрч хичээлээ үзсэний дараа заавал Гарах холбоосыг ашиглаж сайтаас гарна. Ингэснээр таны нэрээр өөр хэн нэгэн нэвтэрч мэдээллийг чинь өөрчлөх эрсдэлээс хамгаална. Сайтаас гарахдаа Гарах (Sign out) холбоос дээр дарж гарна. Зураг 2




Зураг 2. Цахим сургалтын систем Dashboard буюу удирдах цонх

Profile хуудасны тохиргоо

Хэрэглэгч та баруун дээд буланд харагдаж байгаа нэвтрэх нэр дээр дарж өөрийн Profile хуудасны тохиргоог өөрчлөх / нэвтрэх нэр, нууц үгээ солих.. г.м/ боломжтой.

- My profile settings Тохиргоо
- Тохиргоо хэсэгт нэвтэрснээр дараах байдалтай харагдана. Зураг 3




Зураг 3. Хэрэглэгчийн удирдлагын хэсэг

Хэрэглэгч та өөрийн бүртгэлээ шинэчлэх шаардлагатай бол өөрийн profile хуудасны edit profile хэсэгт орж Нууц үг өөрчлөх хэсэгт хандан нууц үгээ солих боломжтой. Шинэ нууц үгээ оруулсан бол өөрчлөлтийг хадгалах хэсэгт дарснаар таны нууц үг шинэчлэгдэнэ.

Хичээл судлах


Moodle сургалтын программ нь хичээлийг цахимаар суралцагсад хүргэх багш, оюутныг холбох зориулалт бүхий сургалтын программ юм.

Moodle программд хичээл судалж буй оюутанд нэвтрэх нэр, нууц үг өгсөн байх бөгөөд оюутан өөрийн нэвтрэх нэр, нууц үгээ ашиглан программд нэвтэрнэ. Хичээл зааж буй багш өөрийн хичээл дээр оюутнуудыг бүртгэж өгнө. Программд тухайн оюутны суралцаж буй хичээлүүд дараах байдлаар харагдана. Зураг 4




Зураг4. Хичээл программд орсон байдал

Оюутан өөрийн судалж буй хичээлд нэвтрэхийн тулд тухайн хичээлийн нэр дээр хулганаар товшиж өөрийн хичээлд нэвтэрнэ. Хичээл рүүгээ орохоор дараах байдалтай харагдана.



Зураг5. Хичээлийн материалууд

Лекц, семинар, лабораторийн ажлуудыг долоо долоо хоногуудаар дарааллын дагуу хичээлээ байршуулсан байна



Зураг 6. Сургалтын материалыг харгалзах 7 хоногт сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу оруулсан байна

Хичээлийн долоо долоо хоногуудын хэсэгт дараах талбарууд байна.

- Лекц
- Семинар
- Бие даалт 1
- Бие даалт 2
- Шалгалт /Явцын болон улирлын тест авах/
- Оюутнуудад өгөх нэмэлт мэдээлэл оруулах /Шалгалтын хугацаа, бие даалт авах гэх мэт/

Цахим сургалтын программын боломжууд болон зөвлөгөө

The screenshot shows a course dashboard for 'SCR501-2022-2023'. The left sidebar contains navigation options: 'Participants' (highlighted with a red box), 'Competencies', 'Grades' (highlighted with a red box), 'Course sections', and 'English (en)'. The main content area displays the course title 'Шинжлэх ухааны судалгааны арга зүй, I Улирал, Доктор, дэд профессор Ч. Төрбадрах (2022-2023, Магистр)'. Below this is a 'Participants' section with a search filter (Match: Any, Select) and buttons for '+ Add condition', 'Clear filters', and 'Apply filters'. A message indicates '44 participants found'. A dropdown menu for 'First name' is set to 'All', with a letter selection bar (A-M). On the right, there is a 'Completion Progress' bar for 'NOW' and a 'Logged in user' profile for 'Даргасүмбэрэл Цэрмаа' with details: Country: Mongolia, City/town: Улаанбаатар, Email address: ba22e022@mandakh.edu.mn.

Зураг 8. Хичээлийг сонгосон оюутнууд ба дүнгээ харах

Participants – Хичээлд судалж буй оюутнуудын жагсаалт Зураг 9


The screenshot shows the 'Participants' list page. The left sidebar is similar to the previous image, with 'Participants' highlighted. The main content area features a search filter for 'Surname' set to 'All', with a letter selection bar (A-M). Below this is a table of participants:

First name / Surname	Roles	Groups	Last access
Эрдэнэхүү Азжаргал	Student	1-р хэсэг НББ	53 days 18 h
МӨНХТУУЛ АЛТАНБАГАНА	Student	1-р хэсэг НББ	46 days 16 h
Шинэцэцэг Амартөр	Student	1-р хэсэг НББ	23 hours 10 m
одмаа ахисан түвшний сургууль	No roles	No groups	7 mins 50 s

On the right, there are sections for 'Latest announcements' (no announcements posted yet), 'Upcoming events' (no upcoming events), and 'Recent activity' (activity since Tuesday, 3 January 2023, 2:25 PM).


Зураг 9. Хичээлд судалж буй оюутнуудын жагсаалт

Grades – Оюутан дүнгээ харах хэсэг Зураг 10




Зураг 10. Оюутан дүнгээ харах хэсэг

Багш Participants хэсгээр орж хичээл судалж буй оюутнуудын жагсаалт харах ба тэмдэглэсэн баганад хамгийн сүүлд хэзээ систем рүү нэвтэрсэн мэдээллийг харж болно. Зураг 11.



Зураг 11. Оюутнууд системд нэвтэрсэн байдал

Багш руу бие даалт, даалгавраа явуулах хэсэг

Assignment буюу  гарын зурагтай талбар нь бие даалт, даалгаврыг илэрхийлнэ. Тухайн бие даалт, даалгавар нь хугацаатай байх бөгөөд хоцорсон тохиолдолд файл илгээх боломжгүй. Багш руу явуулах даалгавар нь бүх төрлийн файлыг хүлээн авах боломжтой.


Зураг 12

Суралцагсад энэхүү загвар, зөвлөмжийн дагуу бие даалт, даалгавар, судалгааны ажлаа бэлтгэн явуулж байна.

Судалгааны ажлын бичилтийн загвар: <http://mandakh.edu.mn/news/299/single/3450>


Бие даалтын ажлын бичилтийн загвар: <http://mandakh.edu.mn/news/300/single/3451>

Судалгааны ажил бичихзөвлөмж: <http://mandakh.edu.mn/news/266/single/3266>




Зураг 12. Оюутны бие даалт, даалгавар

Due Date багш руу файл явуулах сүүлийн хугацаа харагдах бөгөөд **Add Submission** товчоор даалгавраа явуулна. Зураг 13




Зураг 13. Бие даалт явуулах хэсэг мэдээлэл


Файлаа оруулаад Save changes товчийг дарснаар файл багш руу илгээгдэнэ. Зураг 14



Зураг 14. Бие даалт явуулах хэсэг

Шалгалт өгөх хэсэг


Quiz буюу  зурагтай талбар нь шалгалтыг илэрхийлнэ. Зураг 15



Зураг 15. Шалгалт өгөх хэсэг

Тухайн шалгалт эхлэх хугацааг шалгалт дээр дараад мэдэж болно. Шалгалт эхлэх цаг болоход шалгалт руу нэвтрэх товч идэвхтэй болох бөгөөд шалгалт дуусах хугацаанд цахим систем бүх оюутнуудын шалгалтыг автоматаар дуусгаж оноог тооцоолж оюутанд мэдэгдэнэ. Иймээс шалгалтын эхлэх цагаас хоцорч болохгүй бөгөөд шалгалт дуусах хугацаанаас өмнө амжиж шалгалтаа дуусгах хэрэгтэй. Зураг 17


Жишээ нь: Зураг 17 дээрх жишээг сайтар харна уу. Тухайн шалгалт 20:00 цагт эхлээд 21:00-д дуусна. Шалгалтын үргэлжлэх хугацаа 40 минут. 21:00-д автоматаар систем шалгалтыг хаана гэсэн үг юм.



Зураг 16. Шалгалтын хэсэг


Багштай харилцах хэсэг

Багштай харилцахын тулд баруун дээд буланд мессеж бичих  товчин дээр дарна. Зураг 17




Зураг 17 мессеж бичих хэсэг

Харилцах багшийн нэрийг оруулж хайна. Зураг 18



Зураг 18. Мессеж бичих хэсэг, багшийн нэрийг хайж байна.


4. Багц цагийн тодорхойлолт нь Мандах Их Сургуультай ижлээр тодорхойлогдсон хичээлийн багц цагийг тэр хэвээр нь ашиглах бөгөөд багц цагийг өөрөөр тодорхойлсон гадаадын их, дээд сургууль, коллежид судалсан хичээлийг дүйцүүлэн тооцохдоо тухайн сургуулийн сургалтын цагийн тухай албан ёсны тайлбар заавал шаардана. Энэ тохиолдолд тухайн багц цагийн тодорхойлолт дахь суралцагчийн ачааллыг Мандах Их сургуулийн багц цагийн харгалзах үзүүлэлтүүдэд шилжүүлэн тооцно.

4.1 Гадаадын их, дээд сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг ялгаатай багц цагийг Хүснэгт 1-д заасны дагуу шилжүүлэн тооцно.

4.2 Журмын 3.1.2-г тусгасан нөхцөлөөс бусдаар Мандах Их сургуульд дүйцэх хичээлийн багц цагт хүрэхгүй бол шилжүүлэн тооцохгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлах мэтээр нөхөн гүйцээхгүй.

4.3 Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн багц цаг болон агуулга, суралцахуйн үр дүн нь нийлээд Мандах Их сургуулийн харгалзах хичээлийн багц цаг, агуулга, суралцахуйн үр дүнгийн шаардлагыг хангаж байвал тухайн хичээлүүдийг нэгтгэн дүйцүүлж болно.

4.4 Суралцагчийн судалсан нэг хичээл нь Мандах Их Сургуулийн хэд хэдэн хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, багц цагийн шаардлагыг хангасан бол тэдгээр хичээлүүдийг тус тусад нь дүйцүүлж болно.

Тав. Суралцагчийн үнэлгээ (дүн)-г дүйцүүлэх аргачлал

5.1 Бусад дээд боловсролын сургалтын байгууллагуудад түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг Хүснэгт 2-т заасны дагуу хөрвүүлэн тооцно.

5.2 Суралцагчийн хичээлийн үнэлгээ нь Мандах Их Сургуулийн үнэлгээний системээс (дүнгийн шатлал) өөр бол тухайн сургуулийн дүнгийн шатлалын тухай албан ёсны тайлбарыг шаардах бөгөөд хэрэв боломжгүй бол амжилттай дүнг 60-95 онооны засварт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцно. Тухайлбал, тухайн сургууль оюутны мэдлэгийг онц, сайн, дунд, муу гэж үнэлдэг бол 60-71, 72-83, 84-95, оноог амжилттай дүнд харгалзуулан дунд -66, сайн -78, онц-90 гэж оноох юм уу, эсвэл үнэлгээг тооцсон багц цагийн нарийвчлалтай холбож багц цагийг бууруулан тооцсон бол интервалын дээд оноог харгалзуулж болно.

5.3 Журмын 4.5-д заасны дагуу нэг хичээлээр Мандах Их Сургуулийн хэд хэдэн хичээл бүрийн үнэлгээ нь дүйцүүлэх хичээлийн үнэлгээтэй адилхан байна.

5.4 Өөр сургуульд судалсан хичээлийг дүйцүүлэн тооцох тохиолдолд үсгэн үнэлгээг CR (credit granted) тэмдэглээгээр оруулна.

Зургаа. Хэлний шалгалтын оноог дүйцүүлэх

- 6.1 Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй оюутан хүсэлт гаргавал, улирлын эхэнд түвшин тогтоох шалгалт авч, шалгуур хангасан оюутанд бие даан суралцуулах буюу улирлын шалгалтаас чөлөөлж болно.
IELTS-ын Academic module-ын 5.0-аас дээш оноотой
TOEFL-ын Academic module-ын 450-аас дээш оноотой
- 6.2 Дүйцүүлж болох олон улсын шалгалтын нэр, түвшин тогтоосон сертификатын хүчинтэй хугацаа болон дүйцүүлж болох хичээлийн нэр, багц цагийг мэргэжлийн тэнхим хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 6.3 Мандах Их Сургуулийн бакалаврын түвшний суралцагчид тавигдах гадаад хэлний ерөнхий шаардлагыг тухайн хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноогоор хангасанд тооцож болох ба 6.1-д заагдсанаас бусад тохиолдолд олон улсын шалгалтын оноогоор Мандах Их Сургуулийн хичээл дүйцүүлэхгүй.
- 6.4 Гадаад хэлний шалгалтын сертификатын оноогоор Мандах Их Сургуулийн ахисан түвшний хөтөлбөрийн хичээл дүйцүүлэхгүй.

Долоо. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа

- 7.1 Мандах Их Сургуулийн хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг сургалтын алба, мэргэжлийн тэнхимтэй хамтран зохион байгуулна.
- 7.2 Суралцагч хичээл дүйцүүлэх тухайн өргөдлийг батлагдсан маягтын дагуу холбогдох материалуудын хамт сургалтын албанд гаргах ба хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянан үзэж, журмын шаардлага хангасан тохиолдолд хичээл дүйцүүлэлтийн маягтын дагуу бөглөж Сургалтын албаны дарга баталгаажуулна.
- 7.3 Мандах Их Сургуульд дүйцүүлж буй хичээл нь Мандах Их Сургуулийн хичээл дүйцүүлэлтэд баримтлах зарчим болон харгалзах хичээлтэй агуулгаараа давхцаж байгаа эсэх (журмын 3-р бүлэг), багц цагийн хэмжээ нь шаардлага (журмын 4-р бүлэг) хангаж буй эсэх талаар тухайн хичээлийг хариуцан заадаг мэргэжлийн тэнхим (тэнхимийн эрхлэгч эсвэл тухайн хичээлийг заадаг багш)-ийн дүгнэлт/ зөвшөөрлийг заавал авсан байх ба харгалзах тэнхимийн эрхлэгч нь баталгаажуулсан байна.
- 7.4 Журмын 7.3-д заасан мэргэжлийн тэнхимийн зөвшөөрөл бүхий дүйцүүлж болох хичээлийн дүнгийн дүйцүүлэлтийг энэхүү журмын 5-р бүлэгт заасан аргачлалын дагуу сургалтын албаны мэргэжилтэн хийнэ.

Найм. Бусад

- 8.1 Хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг элссэн, шилжсэн, эргэн суралцсан тухайн улиралд суралцагчийн хүсэлтээр нэг удаа хийнэ.
- 8.2 Хичээл дүйцүүлэлтийг аргачлалын дагуу зөв хийгээгүй тохиолдолд дүйцүүлэлтийг буцааж, дахин засварлаж оруулна.
- 8.3 Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал Мандах Их Сургуулийн захиргааны зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.

Түгээмэл хэрэглэгддэг дүнгийн нэмэлт тэмдэглэгээ, түүний тайлбар

Хүснэгт 1

Үсгэн тэмдэглэгээ	Тайлбар	Голч дүн болоход уг тэмдэглэгээ бүхий дүнг тооцох эсэх	Дүнгийн тодорхойлолтод уг тэмдэглэгээ бичигдэх эсэх	Төгсөлтийн баримт бичигт уг тэмдэглэгээ бичигдэх эсэх
NA	(final grade Not yet Available) Одоогоор дүгнэгдээгүй буюу судалж байгаа хичээлийн тэмдэглэгээ.	Үгүй	Үгүй	Үгүй
G	(Graded) Бүрэн дүгнэгдэж дууссаныг илтгэх тэмдэглэгээ.	Тийм	Үгүй	Үгүй
W	(Withdraw) Хичээлийн агуулгын 2/3-аас багагүйг судалсан, явцын үнэлгээний нийлбэр 60-аас дээш боловч хичээлийн эцсийн үнэлгээгээ зохих түвшинд хүрэхгүй гэж суралцагч үзвэл улирал дуусахаас 7 хоногийн өмнө өөрийн хүсэлтээр багшид хүсэлт гаргаж хийлгэх тэмдэглэгээ. Тус хичээлийг дахин судлах бол шинээр үзэх хичээлийн нэгэн адил бүртгүүлж судална.	Үгүй	Тийм	Үгүй
WF	(Withdrawal Fail) Суралцагч хичээлийн аль нэг хэлбэрийн 2/3-аас илүүд суугаагүй тохиолдолд багш тухайн хичээлийн улирал дуусахаас 7 хоногийн өмнө тавих тэмдэглэгээ.	Тийм	Тийм	Үгүй
NR	(No grade Reported) Багш нь дүгнэх хугацаанд багтааж дүгнээгүй тохиолдолд тавих тэмдэглэгээ. Дүнгийн гомдол маргааны хугацаанд суралцагчийн зүгээс дүнгийн гомдол гаргаагүй тохиолдолд тухайн хугацаа дууссаны дараа суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.	Тийм	Тийм	Үгүй
R	(Repeat) Тухайн хичээлийг амжилттай судалсан ч дахин судлах хүсэлт гаргасан бол дахин судлах боломжоор хангах тэмдэглэгээ.	Үгүй	Тийм	Үгүй
I	(Incomplete) Хүндэтгэн үзэх шалтгаанаар явцын үнэлгээ дутуу үед тавих тэмдэглэгээ. Суралцагч нөхөн шалгуулах хугацаанд багтааж шалгуулан дүгнүүлэх ба уг хугацаанд багтаж дүгнүүлээгүй тохиолдолд суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ. Түүнчлэн улирал дамнан гүйцэтгэж буй дадлага, эрдэм шинжилгээний ажил зэрэгт энэ тэмдэглэгээг хэрэглэж болно.	Үгүй	Тийм	Үгүй

E	(Examine incomplete by student) Хүндэтгэн үзэх шалтгаанаар улирлын шалгалтад ороогүй бол багш энэ тэмдэглэгээг тавина. Суралцагч нөхөн шалгуулах хугацаанд багтаж шалгуулан дүгнүүлэх ба уг хугацаанд багтаж дүгнүүлээгүй тохиолдолд суралцагчийн цуглуулсан онооноос хамааруулан харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлнэ.	Үгүй	Тийм	Үгүй
CA	(Cancelled) Суралцагч хугацаат цэргийн албанд татагдсан, хязгаарлалт хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт 2 сараас их хугацаанд байсан, гэнэтийн осолд өртсөн, хүнд өвчний улмаас мэс засал хийлгэсэн тохиолдолд тавигдах тэмдэглэгээ. Суралцагч дахин судлах тохиолдолд төлбөр шаардахгүйгээр үргэлжлүүлэн суралцах боломжийг олгоно.	Үгүй	Тийм	Үгүй
CR	(Credit gRanted) Өөр сургуулийн дүйцүүлсэн хичээлийг тодотгох тэмдэглэгээ.	Тийм	Тийм	Үгүй
RC	(ReConsidered) Дүнгийн гомдол маргаанаар засварлагдсан дүнг илэрхийлэх тэмдэглэгээ	Тийм	Тийм	Үгүй

Бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн хичээлд дүйцүүлэн тооцох
Кембриджийн болон олон улсын хөтөлбөрийн хичээл

Хүснэгт 2

Кембрижийн хөтөлбөрийн шалгалтын нэр	Ерөнхий суурь хичээлийн чиглэл
Математик (9709)	Математик болон статистикийн чиглэлийн хичээл
Физик (9702)	Физикийн чиглэлийн хичээл
Хими(9701)	Химийн чиглэлийн хичээл
Биологи (9700)	Биологи болон экологийн чиглэлийн хичээл
Дэлхий нийтийн чиг хандлага (8987)	Олон улсын харилцаа, даяаршиллын чиглэлийн хичээл
Арт & Дизайн (9704)	Урлагийн чиглэлийн хичээл
Эдийн засаг (9708)	Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлийн хичээл

Түгээмэл хэрэглэгддэг багц цагийн харьцааны үзүүлэлт

Хүснэгт 3

Монгол	ECTS	АНУ*	БНХАУ	Энэтхэг	Япон	БНСУ	ОХУ*	Австрали	Канад	Сингапур
1 багц цаг	2	1	1	1	1	1	2	2	0.17	1.6

* Улирлын (quarter) багц цагт суурилсан кредит системтэй сургууль бол багц цагийг 3/2 коэффициентод хувааж тооцно.

** Багц цагаар хэмжигддэггүй, танхимын цагаар тодорхойлогддог сургалтын системтэй бол 72 танхимын цагийг 1 багц цаг гэж үзнэ.

Гадаадын түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг хөрвүүлэн тооцох аргачлал

Хүснэгт 4

Монгол	A				B				C				D				F		
	100	95	95	90	89	85	85	80	79	75	75	70	69	65	65	60	59		
ECTS	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	C	D	D	E	E	F	F	F
	Exc	Exc	Exc	Exc	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Good	Satis	Satis	Pass	Pass	Fail	Fail	Fail
Хятад	100	95	95	90	89	85	85	80	79	75	75	70	69	65	65	60	59		
Тайван	100	95	90	80	79	75	75	70	69	65	65	60					59>	59>	59>
Орос	100	95	95	90	87	84	83	80	79	75	75	70	65	60	55	50	49		
	5	5	5	5	5	4	4	4	3	3	3	3	3	3	3	3	2		
	excell ent	excele nt	excell ent	excell ent	excell ent	excell ent	good	good	satisfac tory	satisfac tory	satisfac tory	satisfac tory	satisfac tory				fail		
Япон	S/A+ 100	S/A+ 95	S/A+ 95	S/A+ 90	A 89	A 89	A 85	A 85	A 80	B 79	B 75	B 75	B 70	C 69	C 65	C 60	F/D 40-59	F/D 40-59	F/E <40
Англи, Ирланд	85,A	80,A	73,A	70,A	67, B+	65,B+	63, B+	60,B+	57,B	55,B	53,B	50,B	47,C+	45,C+	43,C	40,C	35,D	30,D	<30,E, F
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
Итали	30	30	30	30	29	27	25	23	22	21	21	20	19	18	18	17	16	15	<15
Бельги, Франц	20	20	19	19	18	18	17	17	16	16	15	14	13	12	11	10	9	8	<8
Португал	20	19	18	17	16	15	14	14	13	13	12	12	11	11	10	10	9	7	<5
Дани	12	12	12	12	10	10	10	10	7	7	7	7	4	4	2	2	0	0	0
Голланд	10	9	9	9	8	8	7	7	6	6	6	6	5.5	5.5	5	5	4	3	<3
Литва	10	10	9	9	8	8	8	8	7	7	6	6	5	5	5	5	4	3	2
Испани, Румын	10	10	9	9	8	8	8	7	7	7	6	6	5	5	5	5	4	3	2,1
Исланд	10	10	9	9	8	7	7	7	6	6	6	6	5	5	5	5	4	4	3,2,1
Грек, Кипр	10	10	9	9	8	8	8	8	7	7	6	6	5	5	4	4	3	2,1	0
Швейцар	6	5.75	5.5	5.25	5	5	4.75	4.75	4.5	4.5	4.5	4.5	4.25	4.25	4	4	<4	<4	<4
Болгар	6	6	6	6	5	5	5	5	4	4	4	4	3	3	3	3	2	2	2

Польш(2)	5	5	5	5	4+	4+	4+	4+	4	4	4	4	3+	3+	3	3	2	2	2
Унгар, Швед, Хорват	5	5	5	5	4	4	4	4	3	3	3	3	2	2	2	2	1	1	1
Финланд(1)	3	3	2.5	2.5	2	2	2	2	1.5	1.5	1.5	1.5	1	1	1	1	0	0	0
МУ	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
Норвег	1.6	1.7	1.8	1.9	2	2.1	2.3	2.5	2.6	2.7	2.8	2.9	3	3.3	3.5	4	4.1	4.5	5
Герман	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	3	4	4	4	4	5	5	6
Австри	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	3	4	4	4	4	5	5	5
Чех	1	1	1	1	2	2	2	2	2	2	2	3	3	3	3	3	4	4	4
Эстони	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	C	D	D	E	E	F	F	F
Мальт	A+	A	A	A	B+	B+	B	B	C+	C+	C	C	D+	D+	D	D	F	F	F
Өмнөд солонгос	A+	A	A	A-	B+	B	B	B-	D+	D	D	D-					F	F	F
Турк	AA	AA	AA	AA	BA	BA	BA	BA	BB	BB	CB	CB	CC	CC	DC	DD	F	F	F
Хонгконг, ЭНЭТХЭГ	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	C	D	D	D	D	F	F	F
Словак	Exc A	Exc A	Exc A	Exc	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Satis	Satis	Satis	Pass	Pass	Fail	Fail	Fail
				A	B	B	B	B	C	C	C	D	D	D	E	E	F	F	F
Словени	Exc A	Exc A	Exc A	Exc	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Satis	Satis	Satis	Pass	Pass	Fail	Fail	Fail
				A	B	B	B	B	C	C	C	D	D	D	E	E	F	F	F
Сингапур	Class I	Class I	Class II i	Class II i	Class II ii	Class II ii	Class II ii	Class II ii	Class III	Class III	Class III	Class III							

3.4 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛЫН БАГЦ ЦАГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь БШУ-ны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, БШУ-ны сайдын 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/92 тоот тушаалаар батлагдсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”, мөн БСШУ-ны сайдын 2007 оны 187 тоот тушаалаар батлагдсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”, Маднах Их Сургуулийн Захирлын 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/89 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах журам”-ийг тус тус үндэслэнэ.
- 1.2. Мандах Их Сургуулийн магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон магистрын мэргэжлийн дадлага хамгаалах, тэдгээртэй холбоотой эрдэм шинжилгээний багц цаг тооцохтой холбоотой асуудлыг энэхүү журмаар зохицуулна..

Хоёр. Эрдэм шинжилгээний багц цаг тооцох

- 2.1. Магистрант, докторантын эрдэм шинжилгээний багц цаг тооцох комиссыг 3-аас цөөнгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, сургуулийн захирлын тушаалаар томилно.
- 2.2. Эрдэм шинжилгээний багц цаг цуглуулсан тухай удирдагчийн тодорхойлолт болон батлах судалгааны материал, дадлагын тайлан зэрэгт үндэслэн комисс магистрант, докторантын эрдэм шинжилгээний багц цагийг тооцно.
- 2.3. Магистрын эрдэм шинжилгээний багц цагийг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно.
Үүнд:
 - 2.3.1 Судалгааны чиглэлээр суралцаж буй магистрант нь мэргэжлийн судалгаа, онолын семинарт бүрэн хамрагдсан бол 1.5 багц цаг
 - 2.3.2 Мандах ИС-ийн АТС-аас зохион байгуулсан мэргэжлийн семинар, их семинарт 2-оос доогүй удаа хамрагдсан бол 0.1 багц цаг
 - 2.3.3 Мандах ИС-ийн АТС-аас зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн чиглэлийн цуврал сургалт, хэлэлцүүлэгт 3-аас цөөнгүй удаа суусан бол 1 багц цаг
 - 2.3.4 Туршилт судалгаа хийсэн, судалгааны ажлын үр дүнгээ сургуулийн магистрантуудын эрдэм шинжилгээний хурал дээр илтгэж хэлэлцүүлсэн бол 1 багц цаг
 - 2.3.5 Үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 1 багц цаг
 - 2.3.6 Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн бол 2 багц цаг
 - 2.3.7 Эрмийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн бол 1.5 багц цаг
 - 2.3.8 Олон улсын редакцын зөвлөл бүхий гадаад хэл дээр хэвлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн бол 3 багц цаг
 - 2.3.9 Профессорын туслах судлаачаар ажилласан бол 1 багц цаг

- 2.3.10 Мандах ИС-ийн нэр дээр үндэсний хэмжээний гэрээт ажил, захиалгат төсөл болон судалгааны ажилд хамрагдсан бол 2 багц баг
- 2.4. Докторын эрдэм шинжилгээний багц цагийг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно.
Үүнд:
- 2.4.1 Мандах ИС-ийн АТС-аас зохион байгуулсан мэргэжлийн семинар, их семинарт 5-аас доогүй удаа хамрагдсан бол 1 багц баг
- 2.4.2 Мандах ИС-ийн АТС-аас зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн чиглэлийн цуврал сургалт, хэлэлцүүлэгт 6-аас цөөнгүй удаа суусан бол 1 багц цаг
- 2.4.3 Докторын судалгааны ажлын үр дүнгээ сургуулийн докторант оюутнуудын эрдэм шинжилгээний хурал дээр 3-аас цөөнгүй удаа илтгэж хэлэлцүүлсэн бол 1.5 багц цаг
- 2.4.4 Тэнхим болон сургуулийн хэмжээний эрдэм шинжилгээний хуралд 10-аас цөөнгүй удаа илтгэл хэлэлцүүлсэн бол 2 багц цаг
- 2.4.5 Үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хуралд 6-аас цөөнгүй удаа илтгэл хэлэлцүүлсэн бол 3 багц цаг
- 2.4.6 Олон улсын эрдэм шинжилгээний хуралд 3-аас цөөнгүй удаа илтгэл хэлэлцүүлсэн бол 4 багц цаг
- 2.4.7 Эрмийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд 5-аас цөөнгүй удаа өгүүлэл нийтлүүлсэн бол 1.5 багц цаг
- 2.4.8 Олон улсын редакцын зөвлөл бүхий гадаад хэл дээр хэвлэгддэг эрдэм шинжилгээний сэтгүүлд 2-оос цөөнгүй удаа өгүүлэл нийтлүүлсэн бол 3 багц цаг
- 2.4.9 Профессорын туслах судлаачаар ажилласан бол 1 багц баг
- 2.4.10 Мандах ИС-ийн нэр дээр үндэсний хэмжээний гэрээт ажил, захиалгат төсөл болон судалгааны ажилд 2-оос цөөнгүй удаа хамрагдсан бол 1 багц баг
- 2.4.11 Гадаадад болон дотоодод монограф хэвлүүлсэн бол тус бүр 6-аас 4 багц баг
- 2.4.12 Ном, гарын авлага болон сурах бичгээр багц цаг тооцохгүй болно.
- 2.5. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй, мэргэжлийн түвшинд хянагддаг /peer-review/ сэтгүүлийн жагсаалтыг Монгол улсын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн журамд заагдсан сэтгүүлийн жагсаалтыг баримтална. Эдгээр сэтгүүлийн жагсаалтад beall-ийн жагсаалтад багтах хуурамч сэтгүүлүүдийг оруулахгүй.
- 2.6. Өгүүлэл нь нийтлэгдэхээр зөвшөөрөгдсөн, сэтгүүлийн албан ёсны захиаг ирүүлсэн тохиолдолд эрдэм шинжилгээний багц цагт тооцно.

Гурав. Магистрын мэргэжлийн дадлага хийх, хамгаалах

- 3.1. Мэргэжлийн дадлагын хөтөлбөрийг магистрын хөтөлбөрийн багууд боловсруулж, Ахисан түвшний сургуулийн захирлаар хянуулан, хөтөлбөрийн хороо батална.
- 3.2. Дадлагын хөтөлбөрийн нэр, индекс, багц баг, дадлагын ажлын зорилго, эзэмшүүлэх мэдлэг, чадвар болон түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд, дадлагын хугацаа, зохион байгуулах хэлбэр, дадлага хийх газар, дадлагын тайлангийн бүтэц зэргийг оруулна.

- 3.3. Мэргэжлийн дадлагын ажлыг магистрант нь удирдамжийн дагуу удирдагч багшийн удирдлага дор гүйцэтгэх бөгөөд тайланг 3-аас доошгүй гишүүнтэй комисст хамгаална. Магистрын мэргэжлийн дадлага хамгаалуулах комиссыг сургуулийн захирлын тушаалаар томилно.
- 3.4. Комисс нь дадлагаар эзэмшсэн мэдлэг, чадварыг хөтөлбөрийн дагуу үнэлэх ба гишүүдийн дундаж үнэлгээ 70-аас дээш бол “Хангалттай” гэж үзэн магистрын дадлагын ажил хамгаалсан тухай тогтоол гаргана.

3.5 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Мандах Их Сургуулийн дүрэм /МУ-RU-01:2018/, Мандах Их сургуулийн Соёлын стандарт /МУ-ST-1:2019/ оюутантай байгуулсан суралцах тухай гэрээ, Монголын оюутны ёс зүйн дүрэмд нийцсэн байна.
- 1.2 Мандах Их Сургууль нь ардчилал, хүний эрхийг дээдлэн, аливаа хүчирхийлэл, авлига, дарамт сүрдүүлгээс ангид байж оюутны суралцах таатай орчныг бүрдүүлэхэд анхаарлаа чиглүүлж ажиллана.
- 1.3 Мандах Их Сургуульд суралцагч нь энэхүү дүрмийг хэрэгжүүлэгч нь байна.

Хоёр. Оюутны ёс зүйн зарчим

- 2.1 Мандах Их Сургуулийн оюутан нь Монгол улсын хууль тогтоомж, сургуулийн дүрэм журам, соёлын стандарт, суралцах тухай гэрээгээр хүлээсэн үүрэг болон ёс зүйн энэхүү дүрмийг чанд сахих;
- 2.2 Сургуулийн Эрхэм Зорилгыг дээдлэн, шинжлэх ухаанд шамдан суралцаж, сайн мэргэжилтэн, зөв хандлага, ёс зүйтэй иргэн болохын төлөө өөрийн хүч чадал, авьяас билгээ дайчилдаг манлайлагч оюутан байх;
- 2.3 Эрдэмтэн багш, ажилтан, хамт олноо хүндэтгэн, сургууль, нийгэм, хамт олны үйлсэд идэвхтэй оролцдог байх;
- 2.4 Сургуулийн анги танхим, эд хөрөнгийг ариг гамтай ашигладаг байх;
- 2.5 Хамт суралцаж буй оюутан, суралцагчдад ямар нэгэн ялгаварлал гадуурхал, дарамт шахалт саад хийхгүй, тусалж дэмжин нөхөрсөг даруу дуурайлтай байдлыг эрхэмлэх;
- 2.6 Оюутан нь дээрх үндсэн зарчмуудаас гадна нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээ, суралцаж байгаа мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг сахих;
- 2.7 Ёс зүйн зөрчил гаргасан бол хариуцлагыг хүлээх;

Гурав. Ёс зүйн зөрчилд хамрагдах үйлдлүүд

- 3.1 Ёс зүйн зөрчил гэдэгт ёс зүйн үндсэн зарчмууд болон нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээнд харшилсан дараах үйлдлийг хамруулан авч үзнэ.
- 3.1.1 Мандах Их Сургуулийн Эрхэм Зорилго, нэр хүндийг гутаах, үл хүндэтгэх, сургуулийн захиргааны шийдвэрийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийх.
- 3.1.2 Багш, ажиллагсад, оюутны биед халдах, үл хүндэтгэн дайрч доромжлох, өөрийн хүсэл зорилгыг тулгах, нэр төрийг нь сэвтүүлэх оролдлого хийх.

- 3.1.3 Бусдыг дарамталж сүрдүүлэх, эрх чөлөө, хувийн нууцад нь халдах, бэлгийн дарамт учруулах, хамт суралцаж буй оюутнуудынхаа сурч боловсрох, амгалан тайван амьдрах эрхэд санаатайгаар саад учруулах.
- 3.1.4 Хичээлийн байр, сургуулийн нутаг дэвсгэрт архидан согтуурах, мансуурах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис авч явах, хэрэглэх, тусгайлан зөвшөөрснөөс бусад орчинд тамхи татах, хог хаяж бохирдуулах;
- 3.1.5 Улирлын болон төгсөлтийн шалгалтын журам зөрчих, хичээлийн дүнг өөрчлөх, засвар хийх, хуурамчаар үйлдэх зэргээр сурлагын дүнгийн үнэлгээнд нөлөөлөхүйц зүй бус үйлдэл гаргах;
- 3.1.6 Багш, ажилтан болон эрх бүхий бусад хүмүүст хандан өөртөө ашигтай шийдвэр гаргуулахын төлөө авлига, хээл хахууль өгөх буюу өгөхийг завдах;
- 3.1.7 Ёс зүйн зөрчил гаргасан этгээдийг мэдсэн атлаа түүнийг нь нуун дарагдуулах, өмөөрч хамгаалах, хөхүүлэн дэмжих;
- 3.1.8 Сургуулийн эд хогшил болон сургалтын техник хэрэгслийг санаатай болон болгоомжгүйгээс эвдэх, устгах, өнгө үзэмж, чанарыг алдагдуулах;
- 3.1.9 Сургуулийн удирдлага, багш, хамт олны зүгээс тавьсан зүй ёсны шаардлагыг эсэргүүцэх, биелүүлэхгүй байх;
- 3.1.10 Сургуулийн соёлын стандартын заалтуудыг үл хүндэтгэх, биелүүлэхгүй байх, зөрчих;
- 3.1.11 Нийгмийн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан бусад үйлдэл;

Дөрөв. Бусад

- 4.1 Энэхүү дүрэмд тусгагдсан ёс зүйн зөрчил гаргасан оюутанд зөрчлийн хэр хэмжээ, нөхцөл байдлыг харгалзан “Ёс зүйн хорооны ажиллах журам”/ MU-PR-02:2018EC/-д заасны дагуу хариуцлага хүлээлгэх талаар зохих шийдвэрийг Ёс зүйн хороо гаргана.
- 4.2 Энэхүү дүрмийг тус сургуулийн бүх хөтөлбөрөөр суралцаж буй оюутан суралцагчид дагаж мөрдөнө.
- 4.3 Мандах Их Сургуулийн оюутны ёс зүйн дүрэм /MU-RU-04:2019ST/ болон бусад дүрэм журмаар шийдвэрлэх боломжгүй зөрчлийг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжоор шийдвэрлэгдэнэ.

3.6 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төгсөгчдийн холбоо /цаашид Холбоо гэх/ нь Мандах Их Сургуулийн төгсөгчдөөс бүрдсэн, тэдгээрийн байнгын хамтын ажиллагааг хөгжүүлэх төгсөгчдийн мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрх ашиг сонирхлыг нь хамгаалах зорилго бүхий хамтын удирдлагын сайн дурын үүсгэл санаачилгын олон нийтийн байгууллага мөн.
- 1.2 Холбоо нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд тус сургуулийн дэргэдэх байгууллага юм.
- 1.3 Мандах Их Сургуулийг төгсөгч бүхэн төгсөгчдийн холбооны гишүүн байна.
- 1.4 Холбоо нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, түүний дагуу бусад холбогдох олон нийтийн байгууллагын тухай хуулийг удирдлага болгоно.
- 1.5 Холбоо нь төгсөгчдийн дэлгэрэнгүй бүртгэл бүхий нэгдсэн мэдээллийн сантай байна
Хоёр. Төгсөгчдийн холбооны бүтэц зохион байгуулалт
- 2.1 Холбооны удирдах дээд байгууллага нь холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурал байна.
- 2.2 Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурлаас сонгогдсон тэргүүлэгчид хэрэгжүүлнэ.
- 2.3 Холбоог ерөнхийлөгч удирдана. Холбоо нь тэргүүн дэд ерөнхийлөгч болон хүндэт ерөнхийлөгчтэй байна. Түүнчлэн холбооны тодорхой үйл ажиллагааны чиглэл хариуцсан дэд ерөнхийлөгчидтэй байж болно.
- 2.4 Сургуульд холбоог хариуцсан ажилтан байх ба сургууль болон холбооны үйл ажиллагааны уялдаа холбоо, мэдээллээр ханган ажиллана. Уг ажилтан нь төгсөгчдийн холбооны тэргүүлэгч гишүүн байна.

Гурав. Холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурал

- 3.1 Мандах Их Сургуулийн мэргэжлийн хөтөлбөр бүрийн төгсөгчдөөс 15-аас доошгүй хүнийг оролцуулан холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурал, үйл ажиллагаагаа явуулна.
- 3.2 Холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурал 2 жилд 1 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн буюу холбооны тэргүүлэгчдийн 2/3-ын санаачилгаар ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.
- 3.3 Холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурлын эрх хэмжээ: Төлөөлөгчдийн хурал нь дор дурдсан асуудлыг бүрэн эрхийнхээ хүрээнд хэлэлцэнэ. Үүнд:
 - 3.3.1 Холбооны ажлын төлөвлөгөөг боловсруулах, тайлан гаргах
 - 3.3.2 Холбооны дүрэм, түүнд оруулах өөрчлөлтийг хэлэлцэн батлах
 - 3.3.3 Гишүүдийн жилийн татварын хэмжээг тогтоох
 - 3.3.4 Холбооны үйл ажиллагааны санхүүжилт болон цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх
 - 3.3.5 Жилийн үйл ажиллагааны тайлан гаргаж мэдээлэх
- 3.4 Бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоол, удирдамж, уриалга гаргана.
- 3.5 Бүх гишүүдийн төлөөлөгчдийн хуралд ердийн олонх оролцсон тохиолдолд хурал хүчинтэйд тооцогдоно.
- 3.6 Бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурлаас гарах шийдвэр нь хуралд оролцсон холбооны гишүүдийн ердийн олонхын санал авсан тохиолдолд хүчинтэйд тооцогдоно. Хэрэв санал тэнцвэл хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

Дөрөв. Холбооны тэргүүлэгчдийн хурал

- 4.1 Төгсөгчдийн холбооны тэргүүлэгчид нь 15-20 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 4.2 Тэргүүлэгчдийг холбооны Ерөнхийлөгч удирдана.
- 4.3 Холбооны тэргүүлэгчдийг бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурлаас ил санал хураалтаар сонгоно.
- 4.4 Холбооны бүх гишүүдийн төлөөлөгчдийн хурлын чөлөөт цаг тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах, нөхөн сонгох зайлшгүй шаардлага гарвал холбооны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн төлөөллийн харьцааг баримтлан тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн нэр дэвшүүлж сонгох ба дараа нь бүх гишүүдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулан баталгаажуулна. Нөхөн сонгогдсон тэргүүлэгчдийн бүрэн эрх нь тэргүүлэгчдийн бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар хэрэгжинэ.
- 4.5 Тэргүүлэгчид нь доорх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.5.1 Төгсөгчдийн төлөөлөгчдийн хурлын чөлөөт цагт холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
 - 4.5.2 Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэх асуудал салбар бүрээс сонгогдох төлөөлөгчдийн тоог тогтоож, хуралд хуралдахаас 30 хоногийн өмнө гишүүдэд зарлан бэлтгэл ажлыг хангах
 - 4.5.3 Холбооны үйл ажиллагаанд холбогдох удирдамж, зааврыг батлан гаргах
 - 4.5.4 Гишүүдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах асуудлыг эрх бүхий байгууллагууд оруулж шийдвэрлүүлэх
 - 4.5.5 Холбооны бүтэц, зохион байгуулалт өөрчлөх тухай асуудлыг боловсруулж бүх гишүүдийн төлөөлөгчдийн хуралд оруулах
 - 4.5.6 Холбооны үйл ажиллагааны төсвийг зохистой хуваарилах
 - 4.5.7 Төгсөгчдийн холбоонд гишүүн элсүүлэх, гишүүнээс гаргах асуудлыг хэлэлцэн ерөнхийлөгчид санал оруулах
 - 4.5.8 Тэргүүлэгч тус бүрийн эрхлэх ажил үүргийн хуваарийг батлах
 - 4.5.9 Гишүүний татвар төлөлтийн байдалд хяналт тавих, шаардлага гаргах
 - 4.5.10 Холбооны гишүүдийг төр, засгийн болон бусад шагналд тодорхойлох
 - 4.5.11 Холбооны гишүүдийн гомдол, өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэх ба холбогдох байгууллагад уламжлах
- 4.6 Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- 4.7 Тэргүүлэгчид нь эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлыг хуралдаанаараа хэлэлцэн ердийн олонхын саналаар шийдвэрлэж байна.
- 4.8 Тэргүүлэгчдийн хуралд тэргүүлэгчдийн 50-аас дээш хувь нь ирснээр хүчинтэй тооцогдох бөгөөд асуудлыг хуралд оролцсон тэргүүлэгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 4.9 Тэргүүлэгчдийн хурал хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргана.
- 4.10 Холбооны Ерөнхийлөгч нь дараах эрх, үүрэгтэй байна.
 - 4.10.1 Гадаад дотоод үйл ажиллагаанд холбоог төлөөлөх бүрэн эрхтэй байна.
 - 4.10.2 Холбооны тэргүүлэгчдийн ажлыг удирдан зохион байгуулна.
 - 4.10.3 Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавина.
 - 4.10.4 Тэргүүлэгчдийн хурлыг зохион байгуулан хуралдуулж, хурлыг даргална.
 - 4.10.5 Холбооны бүтэц, зохион байгуулалтын талаар тэргүүлэгчдийн хуралд санал оруулна.
 - 4.10.6 Холбооны үйл ажиллагаатай холбогдсон санал, бусад материалыг хянан шалган тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.
 - 4.10.7 Холбооны мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахад нэгдүгээр гарын үсэг зурна.
 - 4.10.8 Ерөнхийлөгч нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

Тав. Холбооны гишүүдийн эрх, үүрэг

- 5.1 Гишүүд нь дараах эрхтэй байна. Үүнд:
 - 5.1.1 Холбооны гишүүд тэргүүлэгчдийг сонгох болон өөрөө сонгогдох
 - 5.1.2 Холбооны үйл ажиллагаатай холбогдсон санал хүсэлт, гомдлоо Ерөнхийлөгч болон тэргүүлэгчдийн хуралд тавих, түүнийг хэлэлцэхэд оролцох, хариу шаардах
 - 5.1.3 Холбооны ерөнхийлөгч, тэргүүлэгчид болон гишүүдийн үйл ажиллагааг шүүмжлэх
 - 5.1.4 Мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх талаар хүсэлтийг тэргүүлэгчдийн хуралд гаргах, зохиох хөнгөлөлт эдлүүлэх
 - 5.1.5 Ажлын байраар хангахад туслалцаа үзүүлэх болон бусад ашиг сонирхлоо хамгаалах асуудлаар хүсэлт гаргах
- 5.2 Гишүүд нь дараах үүрэгтэй. Үүнд:
 - 5.2.1 Тэргүүлэгчдийн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
 - 5.2.2 Дүрэмд заасны дагуу гишүүний татварыг нэг удаа төлөх
 - 5.2.3 Холбооноос явуулж буй үйл ажиллагаанд идэхтэй оролцох
 - 5.2.4 Өөрийн мэдээлэл нь өөрчлөгдсөн тохиолдолд сургуульд мэдэгдэж бүртгүүлэх
 - 5.2.5 Сургуулиас төгсөгчдөд зориулсан үйл ажиллагаанд оролцож байх

Зургаа. Холбооны санхүүжилт

- 6.1 Холбооны орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 6.1.1 Сургуулийн төсөв
 - 6.1.2 Гишүүний татвар, хандив
 - 6.1.3 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив
- 6.2 Холбооны орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.
- 6.3 Холбооны Ерөнхийлөгч, тэргүүлэгчид холбооны хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Долоо. Холбооны гишүүдэд шагнал, урамшуулал, шийтгэл оногдуулах

- 7.1 Мандах Их Сургуулийг өдөр, эчнээ, магистр, доктор аль ч хэлбэрээр төгссөн төгсөгчид холбооны гишүүн байна.
- 7.2 Гишүүний үүргээ хариуцлагатай сайн биелүүлдэг гишүүдийг дараах хэлбэрээр шагнаж урамшуулна.
 - 7.2.1 Мандах Их Сургуулийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлын 50 хувийг хөнгөлөх
 - 7.2.2 Тус сургуулийн магистрантур, докторантурт элсэн суралцахад хөнгөлөлт үзүүлэх
 - 7.2.3 Тус сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээнд урилгаар оролцох
 - 7.2.4 Сургууль нь мэргэжлийн болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын амжилтаар шилдэг төгсөгчдийг дараах номинаци бүрд нэр дэвшүүлэн шалгаруулан шагнаж алдаршуулна. Үүнд:
 - Мэргэжлээрээ тэргүүлэгч төгсөгч
 - Нийгмийн хариуцлагатай шилдэг төгсөгч
 - Сургуулийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан төгсөгч
 - 7.2.5 Сургуулийн вэбсайтад алдаршуулах
- 7.3 Холбооны дүрмийг зөрчсөн гишүүдэд дараах шийтгэл оногдуулах ба уг эрх нь тэргүүлэгчдийн хуралд олгогдоно.
 - 7.3.1 Сануулах
 - 7.3.2 Гишүүний эрхийг хасах шийтгэл оногдуулна.

3.7 МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭЛД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мандах Их Сургуулийн магистрант, докторантын судалгааны ажлын чанар үр өгөөжийг дээшлүүлэн, шинжлэх ухаан, үйлдвэрлэл инновацын хөгжилд хувь нэмэр оруулахуйц бүтээл туурвилыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Магистрант гэж Мандах Их Сургуулийн магистрын хөтөлбөрөөр суралцагч, докторант гэж Мандах Их Сургуулийн докторын хөтөлбөрийн суралцагч эсвэл Мандах Их Сургуулийн үндсэн багш бөгөөд бусад сургуулийн докторын хөтөлбөрийн суралцагч нарыг ойлгоно.
- 1.3 Энэхүү журам нь магистрант, докторантын эрдэм шинжилгээний бага хурал (цаашид “бага хурал” гэх)-ыг зохион байгуулах, бага хурлаас шалгарсан шилдэг бүтээлд судалгааны тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.4 Магистрант, докторант нь эрдмийн зөвлөлөөр баталгаажуулсан диссертацийн ажлын ерөнхий чиглэлийн дагуу судалгааны ажлын илтгэл бэлтгэж хуралд хэлэлцүүлнэ.
- 1.5 Бага хуралд Мандах Их Сургуулийн магистрант, докторантууд оролцоно.
- 1.6 Эрдэм шинжилгээний бүтээл нь Мандах Их Сургуулийн эрдэм шинжилгээний ажил бичих стандартын дагуу бичигдсэн байна.

Хоёр. Ажлын зохион байгуулалт

- 2.1 Магистрант, докторантын шилдэг бүтээл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурлыг жил бүрийн 10 дугаар сарын III дахь долоо хоногт зохион байгуулна.
- 2.2 Бага хурлыг зохион байгуулах, магистрант, докторантын шилдэг бүтээлийг шалгаруулах ажлыг Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нар хамтран зохион байгуулна.
- 2.3 Бага хуралд оролцогч магистрант, докторант нь дор дурдсан шинжлэх ухааны салбар чиглэлүүдээр бүтээлээ ирүүлж, илтгэл тавьж хэлэлцүүлнэ. Үүнд:
 - 2.3.1 Нягтлан бодох бүртгэл
 - 2.3.2 Банк, санхүү
 - 2.3.3 Менежмент эдийн засаг
 - 2.3.4 Бусад
- 2.4 Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг захирлын тушаалаар батална.
- 2.5 Ажлын хэсэг дор дурдсан үүрэг хүлээнэ.
 - 2.5.1 Жил бүрийн 10 дугаар сарын I дэх долоо хоногт багтаан салбар бүрээр ирүүлсэн магистрант, докторантуудын бүтээлд хянан магадалгаа хийж, судалгааны ажилд тавигдах шаардлага хангасан бүтээлийг сонгон эрдэм шинжилгээний бага хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэх,
 - 2.5.2 Шинжлэх ухааны салбар бүрээр магистрант, докторантын шалгарсан бүтээлүүдийн эмхэтгэлийг гадаад, дотоодын эрдэм шинжилгээний эмхэтгэлд хэвлүүлж, олны хүртээл болгох.
- 2.6 Шилдэг илтгэлийг дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан шалгаруулна. Үүнд:
 - a) Сэдвийн онолын болон практик ач холбогдол, зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс орны нийгэм эдийн засгийн тулгуур асуудлыг хөндсөн байдал
 - b) Судалгааны ажлын шинэлэг, дэвшилттэй тал, үр дүнг хэрэглээ болгох боломж

- с) Судалгааны ажлын төлөвлөлт, онол арга зүйн түвшин, түүнийг эзэмшсэн байдал, дадлага туршлага чадвар
- д) Орчин үеийн судалгаанд ашиглаж буй математик арга, загварчлал, программ хангамж, технологи ашигласан байдал
- е) Дэвшүүлсэн зорилтыг шийдвэрлэсэн байдал, шийдлийг онол арга зүйн талаас болон практик туршилтаар нотолж, бусад судлаачдын хийсэн дүгнэлтүүдтэй харьцуулсан байдал
- ф) Судалгааны үр дүнг үйлдвэрлэл, бизнесийн хэрэглээнд оруулах боломж, ажлын үр дүнгийн практик ач холбогдол.

Гурав. Шилдэг бүтээлийн шалгаруулалт

- 3.1 Магистрант, докторантын шилдэг бүтээл сонгон шалгаруулах комиссыг Мандах Их Сургуулийн захирлын тушаалаар байгуулна.
- 3.2 Магистрант, докторантын шилдэг бүтээл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурлын комиссын дүгнэлтийг үндэслэн судалгааны тэтгэлэг олгоно.
- 3.3 Магистрант, докторантын шилдэг бүтээлийн тэтгэлгийг эрдмийн зэрэг хамгаалах бүтээл боловсруулах, судалгааны ажлын онол, туршилт, үйлдвэрлэлийн үр дүнг бататгах зэрэг зөвхөн судалгааны ажилд зориулан ашиглана.
- 3.4 Шалгарсан магистрант, докторантын шилдэг бүтээлийг Мандах-Эрдэм сэтгүүл, гадаад болон дотоодын бусад эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлд хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.5 Шалгарсан магистрант, докторантыг гадаадын их дээд сургуулиудын оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, төсөл, судалгаа, экспедицийн ажилд нэн тэргүүнд оролцуулах бодлого баримтална.

Дөрөв. Санхүүжилт

- 4.1 Магистрант, докторантын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын шилдэг нэг илтгэлийг шалгаруулж Мандах Их Сургуулийн тухайн жилийн сургалтын төлбөрийн доорх хувьтай тэнцэх дүнтэй судалгааны тэтгэлэг олгоно. Үүнд:
 - а. Магистрантын шилдэг илтгэлд олгох судалгааны тэтгэлэг: 25%
 - б. Докторантын шилдэг илтгэлд олгох судалгааны тэтгэлэг: 50%
- 4.2 Магистрант, докторантын судалгааны ажил болон шилдэг бүтээлийн тэтгэлгийн санхүүжилтийг санхүүгийн жилийн төсөвт тусгана.
- 4.3 Тэтгэлэг авсан магистрант, докторант нь судалгааны ажлын тайланг харьяалагдах судалгааны баг болон Эрдмийн зөвлөлд ирүүлнэ.
- 4.4 Мандах Их Сургуулийн хамтын ажиллагаатай аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар хийлгэсэн тохиолдолд санхүүжилтийн тодорхой хэсгийг захиалагч хариуцна.
- 4.5 Мандах Их Сургуулийн үндсэн багшийн тавьсан илтгэлийг багшийн хөдөлмөрийг үнэлэх журмын дагуу сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн В цагт тооцно.

Магистрант, докторантын эрдэм шинжилгээний
Хавсралт №1. Шилдэг бүтээлд олгох тэтгэлгийн зураглал

Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд
олгох тэтгэлгийн ерөнхий зураглал



3.8 ДОКТОРЫН ДАРААХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТЭТГЭЛЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Мандах Их Сургуулийн сургалт-судалгааны их сургууль болох зорилготой холбогдуулан тус сургуулийн докторын зэрэгтэй судлаач багш нарын туршилт, судалгаа, инновацийн үйл ажиллагаа болон докторын судалгааны ажлаа үргэлжлүүлэхэд дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг дээшлүүлэхэд оршино.
- 1.2 Энэхүү журмаар санхүү, эдийн засаг, хүмүүнлэг, инженер, мэдээллийн системийн докторын (Ph.D) зэрэгтэй судлаачдад Мандах Их Сургуулийн захирлын нэрэмжит докторын дараах судалгааны тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.3 Докторын дараах судалгааны ажилд тэтгэлэг олгох шалгаруулалтыг жилд нэг удаа зохион байгуулах ба нэг удаагийн шалгаруулалтаар 2 хүртэл судалгааны ажилд тэтгэлэг олгоно.
- 1.4 Докторын дараах судалгааны ажлын тэтгэлэгт эрдэм шинжилгээ, туршилтын ажил идэвхтэй гүйцэтгэж буй тус сургуулийн багш нар нээлттэй оролцох боломжтой.
- 1.5 Судалгааны тэтгэлэгийг хэрэгжүүлэх хугацаа 2 жилээс хэтрэхгүй байна.

Хоёр. Судалгааны ажлын тэтгэлэгт нэр дэвшүүлэх

- 2.1 Судалгааны тэтгэлэгт бүтээл нэр дэвшүүлэх эрхийг эрдмийн зөвлөл, бүтцийн сургууль болон тэнхимийн судалгааны баг эдэлнэ.
- 2.2 Нэр дэвшүүлэх бүтээлийн талаар дараах материалыг бүрдүүлж, жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргад ирүүлнэ. Үүнд:
 - 2.2.1 Бүтээл нь дэвшиж буй судлаачийн ажил байдлын тодорхойлолт
 - 2.2.2 Судлаачийн бүтээлийн жагсаалт
 - 2.2.3 Тэтгэлэг горилж буй судалгааны ажлын төсөл
 - 2.2.4 Бүтээлийг нэр дэвшүүлсэн судалгааны багийн хурлын тэмдэглэл зэрэг болно.
- 2.3 Докторын дараах судалгааны тэтгэлэг горилж буй судалгааны төсөл дараах бүтэцтэй байна. Үүнд:
 1. Төслийн нэр
 2. Төслийн санал гаргаж буй судлаачийн/багийн танилцуулга: овог, нэр албан тушаал, мэргэжил, боловсролын зэрэг
 3. Төслийн эхлэх ба дуусах хугацаа
 4. Төсөл гүйцэтгэх үндэслэл ба шаардлага
 5. Төслийн үр дүнгийн шинэлэг, дэвшилтэт тал
 6. Төслийн эдийн засаг, нийгмийн ач холбогдол
 7. Төслөөс гарах үр дүн
 8. Төслийн өртөг зардлын тооцоо

Гурав. Тэтгэлэг олгох шалгаруулалт

- 3.1 Тэтгэлэг олгох судалгааны ажлыг шалгаруулалттай холбоотой ажлыг зохион байгуулах ба ажлын хэсгийг захирлын тушаалаар томилж, ажиллуулна. Ажлын хэсэг нь захирлын тушаалд тусгагдсан эрх, үүргийн дагуу судалгааны тэтгэлэгт нэр дэвшсэн бүтээлд үнэлэлт дүгнэлт гарган ажлын тайлангаа Эрдмийн зөвлөлд ирүүлнэ.
- 3.2 Тэтгэлэг олгох судалгааны ажлыг дараах үзүүлэлтүүдийг харгалзан шалгаруулна. Үүнд:
 - 3.2.1 Судалгааны ажлыг гүйцэтгэх арга зүйн төвшин

- 3.2.2 Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол, нийгмийн болон эдийн засгийн үр өгөөж
- 3.2.3 Судалгааны ажлын шинэлэг дэвшилтэт тал
- 3.2.4 Судлаачийн судалгаа ажил гүйцэтгэх дадлага туршлага, ур чадвар зэрэг болно.
- 3.3 Сонгон шалгаруулах ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн судлаачдад тэтгэлэг олгох асуудлыг захирлын тушаалаар олгоно.

Дөрөв. Судалгааны ажлыг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах

- 4.1 Судалгааны тэтгэлэгт шалгарсан судлаач нь гэрээ байгуулж, захирлаар баталгаажуулснаар түүнийг хэрэгжүүлэх эрх нээгдэнэ.
- 4.2 Төслөөс гарах үр дүнтэй уялдуулан тэтгэлгийн хэмжээ 10 сая хүртэлх төгрөг байна.
- 4.3 Судлаачийн судалгааны ажлын батлагдсан тэтгэлгийн 70 хувийг судалгааны ажил эхлүүлэхэд, үлдсэн 30 хувийг үр дүнг тайлагнасны дараагаар дүгнэлтийг үндэслэн ажлын 5 хоногт багтаан олгох ба гэрээ байгуулах талаар оруулна.
- 4.4 Докторын дараах судалгаа гүйцэтгэж буй судлаач нь судалгааныхаа үр дүнгээр олон улсын хянан магадлагаа хийгддэг импакт фактор 1-ээс дээш бүхий үзүүлэлттэй мэргэжлийн сэтгүүлд тус их сургуулийн нэр дээр нэгдүгээр зохиогч эсвэл хамтарсан зохиогчийн нэрээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх шаардлагатай.
- 4.5 Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн /4.3-т заасан/ бол багшийн хөдөлмөрийн нормын В цаг дутуу үед нөхөж тооцох ба илүү цагийг шилжүүлж тооцохгүй.
- 4.6 Тухайн гүйцэтгэж буй судалгааны ажлын сэдвийн хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, аман илтгэл хэлэлцүүлсэн байна.
- 4.7 Төслийн дүнд бий болсон оюуны өмчийн эзэмшилтийн асуудлыг “Патентын тухай”, “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар зохицуулна.
- 4.8 Тэтгэлэг авсан судлаач өөрийн гүйцэтгэсэн туршилт, судалгаа инновацийн ажлын явц болон судалгааны зардлын зарцуулалтын тайланг боловсруулж, эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 4.9 Судлаач нь хэлэлцүүлсэн тайланг ажлын хэсгийн дүгнэлтийн хамт 15 хоногийн дотор эрдэмтэн нарийн бичгийн дарга, санхүү, хангамж үйлчилгээний албанд хүлээлгэн өгсөн байна.
- 4.10 Судлаач гэрээнд тусгагдсан судалгааны ажлын үр дүнг бүрэн биелүүлээгүй тохиолдолд тэтгэлгээр авсан санхүүжилтийг гэрээнд заасны дагуу сургуулийн санхүүд буцаан төлнө.

Докторантын дараах судалгааны ажлын тэтгэлгийн ерөнхий зураглал





3.9 МАНДАХ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГСДЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журам нь сургалтын төлбөртэй холбоотой сургууль болон суралцагч талуудын харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Сургалтын төлбөрийг тогтоох

- 2.1 Сургалтын төлбөр нь сургуулийн зүгээс оюутанд үзүүлсэн бүхий л үйлчилгээний зардлын эх үүсвэр болно.
- 2.2 Сургалтын төлбөрийн хэмжээг үйл ажиллагааны зардлын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тухайн жилийн инфляцын түвшинтэй уялдуулан, тооцоолж жил бүр шинэчлэн сургуулийн Удирдах зөвлөлийн хурлаас тогтооно.
- 2.3 Хичээл дахин судлах, нэмэлтээр болон нөхөн судлах үед тухайн жилийн Удирдах зөвлөлөөс тогтоосон нэг багц цагийн үнэлгээг үндэслэн төлбөрийн тооцоог хийнэ.

Гурав. Сургалтын төлбөрийг төлөх хугацаа

Нийт оюутнууд сургалтын төлбөрийн 50 хувиас доошгүй дүнг эхний улирлын хичээл эхлэхээс өмнө, үлдэх хэсгийг 2-р улирлын хичээл эхлэхээс өмнө төлж дуусгасан байна.

- 3.1 Сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сангийн оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж, бусад байгууллагын тэтгэлгээр санхүүжүүлэхээр бол сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс сургалтын төлбөрийг урьдчилан төлсөн байна.
- 3.2 Оюутан сургалтын төлбөр төлөхдөө овог нэр, суралцаж буй хөтөлбөрийн нэр, оюутны кодоо тодорхой бичсэн байна.
- 3.3 Оюутны төлбөрийн гүйлгээний мэдээлэл тодорхойгүй бол оюутан санхүүгийн албанд төлбөр төлсөн баримтаа авч ирэн төлбөрийн мэдээллийг тодорхой болгон баталгаажуулна. Төлбөрийн гүйлгээний мэдээлэл тодорхойгүйгээс гарах үр дагаврыг суралцагч өөрөө хариуцна.

Дөрөв. Суралцагчийн шилжилт хөдөлгөөн, сургалтын гэрээ дуусгавар болгох болон цуцлах үед хийгдэх тооцоо

- 4.1 Шинээр элсэгч нь элсэн суралцах эрхийн бичгээ хичээлийн жил эхлэхээс өмнө буцаасан тохиолдолд тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 2%-ийг суутгана.
- 4.2 Суралцагч сургалтын гэрээг дуусгавар болгох болон цуцалсан тохиолдолд суусан хугацааны төлбөр дээр тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 5 хувиар сургуулийн тогтмол зардлын санхүүжилтэд тооцон нэмж суутгана.
- 4.3 Суралцагчийн суусан хугацааг тооцохдоо өргөдөл гаргасан өдрөөр тооцох ба тухайн оюутны эрүүл мэндийн шалтгаан болон бусад хүндэтгэх шалтгааны нотлох баримтыг үндэслэн тухайн хугацааг хасаж тооцож болно.
- 4.4 Оюутан сурлагаар болон ёс зүйн зөрчлөөр хасагдаж буй бол сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.
- 4.5 Жилийн чөлөө авч буй оюутан нь сургалтын төлбөрийн тооцоогүй байна. Хэрэв сургалтын төлбөрийн илүү төлөлттэй бол дараагийн жил рүү шилжүүлэн тооцно.
- 4.6 Дахин болон нөхөн хичээл судлах оюутнууд тухайн хичээлийг судлахаас өмнө кредитийн төлбөрийг төлсөн байна.
- 4.7 Шилжин ирж буй суралцагч нь зээл, тусламжаар суралцаж байсан бол холбогдох байгууллагад хандан гэрээгээ шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн байна.
- 4.8 Сургуулиас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан оюутны суралцсан хугацааны төлбөрийн тооцоог хийхдээ тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийг сургалтын үргэлжлэх хугацаанд хувааж тооцно.


4.9 Оюутан сарын 3 дахь долоо хоногийн хичээлд суусан бол тухайн сарын хичээлд бүтэн суусанд тооцно.

Тав. Бусад

- 5.1 Энэхүү журамд заагаагүй бусад харилцааг оюутантай байгуулсан суралцах гэрээний холбогдох заалтуудыг баримтлан зохицуулна.
- 5.2 Тогтоосон хугацаанд төлөгдөөгүй сургалтын төлбөрийн үлдэгдэлд хоног тутамд 0,3%-ар тооцож алданги төлүүлнэ. Нийт алдангийн дүн нь төлөгдөөгүй төлбөрийн 50 хүртэл хувь байна.
- 5.3 Заасан хугацаанд сургалтын төлбөрөө төлөөгүй оюутанд сургалтын алба, номын сан болон бусад үйлчилгээ үзүүлэхгүй болно.
- 5.4 Энэхүү журмыг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Захирлын тушаалаар баталгаажуулна.

Энэхүү журмыг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Мандах Их Сургуульд суралцагсдын сургалтын
Хавсралт №1 Төлбөрийн талаар баримтлах журам Оюутны сургалтын төлбөрийн талаар баримтлах журмын ерөнхий зураг



3.10 МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ДЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төгсөлтийн ёслол (диплом, энгэрийн тэмдэг гардуулах)-ын үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү дэгийг баримтлан ажиллана.
- 1.2 Мандах Их Сургуулийн багш, ажилтнууд болон төгсөгчид, энэхүү үйл ажиллагаанд оролцогч, зочид энэхүү дэгийг дагаж мөрдөнө.

Хоёр. Үйл ажиллагаа зохион байгуулалт

- 2.1 Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа нь тусгай хөтөлбөрөөр зохион байгуулагдана.
- 2.2 Диплом, энгэрийн тэмдэг гардуулах эрдэмтэн багш, албан тушаалтан болон эрдмийн зөвлөлийн гишүүдийн нэрсийг захирлын тушаалаар батална.
- 2.3 Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааг захирлын тушаалаар батлагдсан зохион байгуулах комисс хариуцан ажиллана. Зохион байгуулах комиссын гишүүн нь бусдаас ялгагдах мандат зүүсэн байна.
- 2.4 Төгсөгчид захирлын тушаалын хавсралтад заагдсан нэрсийн дарааллаар ангийн нэр бүхий суудалд ёслолын үйл ажиллагаа эхлэхээс 15 минутын өмнө суусан байна. Зохион байгуулах комиссын гишүүд хуваарьт суудалд суухад байрлалыг заан тусалж, дэг сахиулж ажиллана.
- 2.5 Төгсөгчдөд ёслолын үйл ажиллагаанд оролцох удирдамжийг зохион байгуулах комиссоос 7 хоногийн өмнө олгоно.
- 2.6 Уг удирдамжид төгсөгч оюутны овог нэр, суух суудлын эгнээ, дугаар, диплом, энгэрийн тэмдэг гардан авах болон буцаж суудалдаа хүрэх чиглэлийг заасан бүдүүвч зураг болон шаардлагатай бусад мэдээллийг агуулсан байна.
- 2.7 Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааны дэгийг зөрчсөн болон хоцорч ирсэн төгсөгчийн диплом энгэрийн тэмдгийг 24 цагийн дараа Сургалтын албанаас олгоно.
- 2.8 Төгсөлтийн баярын үйл ажиллагааг төгсөгчдийн гэрээ хийсэн студийн эсвэл сургуулийн захиргаанаас зөвшөөрөл авсан хөтөлөгч хөтөлбөрийн дагуу хөтлнө. Хөтөлөгч уг дэгийг мөрдөх ба хөтөлбөрийн дагуу ажиллаж, ёслолын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана. /Хөтөлбөрийг хавсаргана./
- 2.9 Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаанд оролцогчид сургуулийн орчинд оргилуун дарс, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.

Гурав. Ёслолын хувцас олгох тухай

- 3.1 Ёслолын хувцсыг төгсөлтийн арга хэмжээ болохоос 3 цагийн өмнө олгож дууссан байх ба төгсөгч барьцааны мөнгө комисст тушаасан байна.
- 3.2 Ёслолын хувцасны загварыг өөрчлөх, хасах, бохирдуулахыг хориглоно.
- 3.3 Төгсөгчид диплом, энгэрийн тэмдэг авахдаа ёслолын хувцсыг заавал өмсөж, үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.
- 3.4 Арга хэмжээ дууссаны дараа ёслолын хувцсыг комисст хүлээлгэн өгөх ба дэгийн 3.2 дугаар заалтыг зөрчөөгүй бол барьцааны мөнгийг буцааж олгоно.
- 3.5 Төгсөх ангийн оюутнууд диплом, энгэрийн тэмдгийн төлбөрөө төгсөлтийн арга хэмжээ болохоос 7 хоногийн өмнө сургуулийн дансанд тушаасан байна.

Дөрөв. Диплом, энгэрийн тэмдэг гардуулах ёслол

- 4.1 Захирлын тушаалаар батлагдсан диплом энгэрийн тэмдэг гардуулах гишүүд тайзнаа тусгайлан зассан суудалд урина.
- 4.2 Сургуулийн удирдлага ёслолын үйл ажиллагаа албан ёсоор нээж үг хэлнэ.
- 4.3 Монгол улсын төрийн дуулал эгшиглэж, танхим дах бүх хүмүүс суудлаас босч хүндэтгэл үзүүлнэ.
- 4.4 Хөтлөгч “Диплом, энгэрийн тэмдэг олгох тухай” захирлын тушаалыг уншиж танилцуулна.
- 4.5 Төгсөгчдөд Захирлын тушаалын хавсралт дах нэрсийн дарааллаар диплом, энгэрийн тэмдгийг гардуулна.
- 4.6 Сурлагын голч дүн хамгийн өндөр 5 хүртэлх төгсөгчийг тусгайлан нэрийг дуудаж баяр хүргэж, диплом, энгэрийн тэмдгийг гардуулах хуваарилалтыг зохион байгуулах комисс гаргасан байна.
- 4.7 Диплом, энгэрийн тэмдэг гардуулалтын үед төгсөгчдийн эцэг, эх, найз нөхдийг тайзан дээр гарахыг хориглоно. Гэрээ байгуулсан студийн эсвэл сургуулийн захиргаанаас зөвшөөрөл авсан зурагчинд төгсөгч нэг бүрийн диплом гардах үеийн зургийг авах эрхийг олгоно.
- 4.8 Диплом, энгэрийн тэмдгээ гардаж авсан оюутан комиссоос өгсөн зааврын дагуу өөрийн суудалдаа суух ба диплом гардуулах үйл ажиллагаанд саад хийх, суудлаа орхихыг хориглоно.
- 4.9 Диплом гардуулсны дараа бүх төгсөгчид суудлаасаа босч тангараг өргөнө. Тангаргийн үгийг төгсөгчийн төлөөлөл уншиж, бусад нь дагаж уншина.
- 4.10 Төгсөлтийн баярын үйл ажиллагааг сургуулийн удирдлагаас төгсөгчдөд баяр хүргэн, амжилт хүсэж, албан ёсоор хааснаар үйл ажиллагаа дуусгавар болно.
- 4.11 Сургуулийн сүлд дуу эгшиглэнэ. Бүх багш, ажилтан, төгсөгчид хамтран дуулна.

